

Улсын бүртгэлийн
дугаар:

Нууцын зэрэглэл:
Б

Аравтын бүрэн
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх даалгаварын
дугаар: 16/1226/2021

**БАТЛАН ХАМГААЛАХ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**“БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ”
ШИФР: “РЕЙТИНГ”**

Даалгаварт төслийн тайлан

Төслийн удирдагч: Т.Соронзонболд

Захиалагч байгууллага: БХЯ-ны ШУТЗ

Санхүүжүүлэгч байгууллага: БХЯ

Гүйцэтгэгч байгууллага: БХЭШХ

Тайлан өмчлөгч: Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн.
13300 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо,
Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран.

Улаанбаатар хот. 2021 он

Улсын бүртгэлийн
дугаар:

Нууцын зэрэглэл:
Б

Аравтын бүрэн
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх даалгаварын
дугаар: 16/1226/2021

**БАТЛАН ХАМГААЛАХ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**“БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ”
ШИФР: “РЕЙТИНГ”**

Даалгаварт төслийн тайлан

Төслийн удирдагч:

Т.Соронзонболд. - БХЭШХ-ийн дэд захирал,
ЭНБДарга, доктор (Ph.D), профессор, хурандаа

Төслийн гүйцэтгэгчид:

Б.Нэргүй. - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША,
доктор (Ph.D), дэд хурандаа

П.Цэдэв. - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭШТА,
доктор (Ph.D), профессор

Б.Баатарсүрэн. - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША,
доктор (Ph.D)

Захиалагч байгууллага:

БХЯ-ны ШУТЗ

Тайлан өмчлөгч:

Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн.
13300 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо,
Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран.
Утас: 453942, Факс: 70150173, Цахим хаяг:
<http://www.mids.gov.mn>; mids@mndu.gov.mn

ГАРЧИГ

РЕФЕРАТ	1
Нэгдүгээр бүлэг: <i>Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаарх иргэдийн оролцооны агуулга, түүний хэлбэрийг хангах үндэслэл</i>	
§1.1. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хэлбэр.....	4
§1.2. Батлан хамгаалах бодлого эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх шинжилгээ	8
§1.2.1. Батлан хамгаалах бодлого эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодлын шинжилгээ	8
§1.2.2. БХЯ-ны бодлого, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээ	17
Дүгнэлт	
Хоёрдугаар бүлэг: <i>Монгол Улсын Зэвсэгт хүчний талаар олон нийтийн үнэлгээний судалгаа</i>	
2.1. Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, цэргийн алба хаагчдын өгсөн үнэлгээ	32
2.2. Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог хангах боломж	39
Дүгнэлт	
ТӨСГСГӨЛ	46
ЭШЛЭЛ АВСАН, АШИГЛАСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ	52

РЕФЕРАТ

Судалгааны үндэслэл:

Улс орныг батлан хамгаалах бодлого нь өргөн цар хүрээтэй, улс орны бүхий л салбарыг хамрахын зэрэгцээ иргэн бүрийн оролцоонд тулгуурласан цогц арга хэмжээ юм. Тиймээс 2016 оны 7-р сарын 21-ний өдөр Монгол улсын Их Хурлаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай" хуулиар Батлан хамгаалах яамыг ерөнхий чиг үүргийн яам болгон үйл ажиллагааны цар хүрээг нь өргөжүүлсэн. Мөн "Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс" (2015) баримт бичигт "Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн¹ гэж тодорхойлсон. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тухай төсөөлөл хүмүүсийн ухамсарт хэн нэгний оролцоогүйгээр бүрэлдэн бий болсон байдаг.

Зэвсэгт хүчин нь нэг талаас төрийн байгууллага, нөгөө талаас нийгмийн бүх давхаргын төлөөлөл болдог. Тиймээс Зэвсэгт хүчний үйл ажиллагааны төрийн нууцад үл хамаарах асуудлаар ард иргэд байнгын мэдээлэлтэй байж иргэний хяналт, иргэдийн оролцоо зөв төлөвшин хөгжих учиртай юм.

Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчин, бодлогын шинэчлэл, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар олон нийт, цэргийн алба хаагчдын санал бодлыг судалж, улмаар салбарын шинэчлэлийн тулгамдсан зарим асуудлуудыг тодорхойлсон давтамжит судалгаа нь аюулгүй байдал, батлан хамгаалах арга хэмжээний үндэс болдог.

Тиймээс батлан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн улсыг батлан хамгаалах бодлого, төлөвлөлт, удирдамж, хууль, эрх зүйн хэрэгжилтийг төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, тэдгээрийн хэрэгжилт, дотоод үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, харилцан уялдаа холбоог хангахад энэхүү судалгааг хийх шаардлага бий болж байна.

Судлагдсан байдал:

БХИС-ийн БХЭШХ-ийн Иргэн-цэргийн харилцаа судлалын төвөөс 1992, 1994, 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000, 2001, 2002, 2004, 2006, 2009, 2011 онд "Батлан

¹"Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс, 2015."

хамгаалах салбарын үйл ажиллагаа, олон нийт, цэргийн алба хаагчдын санал бодол” сэдвээр судалгаа хийж ирсэн байна. Мөн үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар 2002-2003 онд иргэд, цэргийн алба хаагчдын дунд иж бүрэн судалгаа явуулжээ.

ҮБХИС-ийн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвөөс 2016-2019 онуудад Батлан хамгаалах салбарын хэрэглэгчдийн үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

Дээрх судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэн үзвэл улс орны батлан хамгаалах салбарын үйл ажиллагааны талаарх олон нийтийн санал бодлын чиг хандлага, цэргийн алба хаагчид, иргэдийн үнэлэмж, аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаарх тэдний байр суурь, төр, цэргийн удирдлагаас батлан хамгаалах салбарт баримталж буй бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд тэдний оролцоо ямар байгаа хийгээд цэргийн алба хаагчид, тэдний ар гэрийнхний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулан шинжилгээ хийхэд чиглэжээ. Мөн БХЯ-ны талаарх ойлголт, болон бүтээгдэхүүн, үйлчилгээнд өгч буй хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг өмнөх онуудынхтай харьцуулан дүгнэсэн байна.

Судалгааны зорилго: Монгол Улсын Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон нийтийн санал санаа бодолд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлон цаашдын бодлого үйл ажиллагааны санал боловсруулахад оршино.

Судалгааны үр дүн: Батлан хамгаалах салбарын талаарх олон нийтийн үнэлгээ болон рейтинг тодорхой болно.

Судалгааны зорилт:

- Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаарх иргэдийн оролцооны агуулга, түүний хэлбэрийг тодорхойлох;
- Батлан хамгаалах бодлого эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодолд шинжилгээ хийх;
- Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, цэргийн алба хаагчдын өгсөн үнэлгээнд шинжилгээ хийх;
- Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог хангах боломжийг тодорхойлох.

Судалгааны объект: Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа

Судлах зүйл: Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо, санал бодол

Судалгааны арга, түүврийн хэмжээ, төлөөлөх чадвар: Судалгааг хийхдээ зорилтот бүлгээс мэдээлэл авах болон чанарын болон тоон шинжилгээний аргыг хэрэглэв. Судалгааны ажлын түүврийн зохистой хэмжээг хангах үүднээс хүн амын төвлөрөл бүхий газруудыг сонгон нийт 300 гаруй иргэдээс санамсаргүй түүврийн аргаар асуулгын судалгаа авсан. Судалгааны мэдээллийг нэгтгэн, зарим асуудлууд дээр экспертүүдтэй ярилцлага хийж, чанарын болон тоон шинжилгээний аргачлалуудыг ашиглав.

Судалгааны ач холбогдол:

Энэхүү судалгаагаар батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаарх иргэдийн оролцооны агуулгыг тодорхойлж, батлан хамгаалах эрх зүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодолд шинжилгээ хийсэн нь салбарын цаашдын бодлого, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн байдал:

“Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээ. Шифр: “Рейтинг” сэдэвт судалгааны төсөлт ажлыг реферат, 2 бүлэг, 4 зүйл, дүгнэлт, санал бүхий бүтэцтэй тайлан боловсруулав.

Судалгааны ажлын нэгдүгээр бүлгийг: доктор (Ph.D), профессор П.Цэдэв, доктор (Ph.D) Б.Баатарсүрэн (§1.1; §1.2) нар, хоёрдугаар бүлгийг: доктор (Ph.D), профессор, хурандаа Т.Соронзонболд, доктор, дэд хурандаа Б.Нэргүй (§2.1; §2.2) нар бичив. Реферат, төгсгөл, хэсгийг доктор (Ph.D), профессор П.Цэдэв, доктор (Ph.D) Б.Баатарсүрэн нар боловсруулав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ АГУУЛГА, ТҮҮНИЙ ХЭЛБЭРИЙГ ХАНГАХ ҮНДЭСЛЭЛ

§1.1. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хэлбэр

Аливаа улс гүрний хувьд аюулгүй байдлаа хангах асуудал нь иргэн, ард түмний болон төрийн хэвийн оршин тогтнох, хөгжин дэвших хэрэгцээнд суурилсан байдаг. “Үндэсний аюулгүй байдал гэдэг нь нийгмийн бүх организм, олон нийтийн бүтцүүд саад бэрхшээлгүй, хөгжил дэвшилд хүрэх баталгаа бий болж, хувь хүн, нийгэм, төр улсын оршин тогтнох хөгжиж дэвших ирээдүйтэй нөхцөл бүрдсэн байдал”² “Батлан хамгаалах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын аюулгүй байдлыг аливаа үл хүлцэх түвшингийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм эрх зүй, оюун санаа, цэргийн цогц арга хэмжээ, түүний зохион байгуулалт, удирдлага мөн”³ хэмээн зарим судлаачид томъёолсон байна.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын тухай хуульд Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудад Зэвсэгт хүчнийг багтаасан нь⁴ Зэвсэгт хүчин нь Үндэсний Аюулгүй байдлыг хангах субъект болох үндэслэлийг баталж байна. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн Хуулийн Арваннэгдүгээр зүйлд: “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн. Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байна”, “Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно”⁵ хэмээн заасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах үүргийг Монгол Улсын Зэвсэгт хүчин гүйцэтгэхийг хуульчлан баталгаажуулсан байна. Батлан хамгаалах тухай хуулийн /2016/ 5 дугаар зүйлд “Батлан хамгаалах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг мөн”, “Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн

²Ч.Улаанхүү, “Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал”, УБ., 2014, т-76.

³О.Үржин, “Батлан хамгаалахын шинэчлэлийн үндсэн асуудал, нөлөөлөх хүчин зүйл, тэдгээрийн харилцан хамаарлыг судлах онол арга зүй” илтгэл, “Батлан хамгаалах бодлого (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийн эмхэтгэл)”, БХЭШХ, УБ., 2015, т-80.

⁴Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын тухай хууль, 2001.

⁵Монгол Улсын Үндсэн Хууль, 1992.

бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино” гэж тодорхойлсон бол мөн хуулийн Долдугаар бүлэгт “Зэвсэгт хүчин нь үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чиг үүрэг бүхий цэргийн байгууллагын тогтолцоо мөн бөгөөд Монгол Улс мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг бүрдүүлж, бэхжүүлнэ.”, Зэвсэгт хүчний тухай хуулийн /2016/ дөрөвдүгээр бүлэгт “Монгол Улсын Зэвсэгт хүчин нь улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага мөн.” гэж заажээ. Эдгээр хуулийн хэм хэмжээ нь Зэвсэгт хүчнийг нэг талаас нийгмийн харилцаанд оролцогч субъект, нөгөө талаас нь нийгэмд тодорхой эрх, үүрэг хүлээсэн төрийн цэргийн байгууллага буюу Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах нэг субъект болохыг харуулж байна.

Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах асуудал бол зөвхөн цэргийн мөрдөстэй хүмүүсийн үйл хэрэг, тэр дундаа цэргийн удирдах албан тушаалтны шийдвэрээр хийгдэх ёстой ажил биш харин түүнд иргэдийн санал бодол, оролцоо нэн чухал юм. Батлан хамгаалах салбарын бодлого үйл ажиллагааг иргэд нэг талаас татвар төлөгчийн байр сууринаас, нөгөө талаас нийгмийн гишүүний хувьд үнэлдэг тодорхой хэв маяг бүрэлдэн тогтож, энэхүү үнэлэмж нь нийгмийн хүрээнд тодорхой хандлагыг бий болгодог байна.

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй дэлхий дахин, бүс нутгийн аюулгүй байдлын шинэ орчин нөхцөлд Монгол Улс Үндэсний аюулгүй байдлаа хангах шинэ стратеги боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон гадаад бодлогын үзэл баримтлалд аюулгүй байдлаа хангах зарчмыг хуульчилж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын аюулгүй байдал нь “оршин тогтнохуйн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар баталгаажих”⁶ болохыг цогц утгаар нь томъёолсон байна. Энэ нь Үндэсний аюулгүй байдал бол зөвхөн Монгол Улсын, Монголын төрийн оршин тогтнох тухай асуудал бус монголын нийгэм, иргэдийг хамарсан асуудал гэдгийг онцолсон хэрэг юм.

Аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа нь иргэдийн эрх, эрх чөлөө, хүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байх ёстой гэж эндээс ойлгогдож байна. Мөн аюулгүй байдлын үндсэн бүрдэл хэсэг болох тусгаар тогтнол, бүрэн эрхт

⁶Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал түүнчлэн монгол соёл иргэншлийн болон хүн ам, удамшлын сангийн аюулгүй байдлыг хамааруулан үздэг болсон байна.

“Монгол Улсын иргэн бүр үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх, эх оронч үндэсний үзэл, улс үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого үйл ажиллагааны үндэс болно”⁷ гэж заасан нь төр, иргэд, аюулгүй байдлын болон батлан хамгаалах салбарын үйл ажиллагааны стратегид шууд хамааралтай юм. Уг үзэл баримтлалд “даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байгаа”⁸ талаар тусгажээ.

Ардчилал өндөр хөгжсөн орнууд болон ардчилалд шилжиж буй улс оронд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, үр нөлөөг нь сайжруулахад чиглэгдсэн эрхзүйн таатай орчин бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга зам, механизмыг бий болгон бодит үр дүнд хүрсэн байдаг. Тухайлбал, Дани, Их Британи, Канад, ХБНГУ, Словак, Унгар зэрэг улсад зарим туршлага байна:

- бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог дэмждэг;
- нээлттэй хэлэлцүүлэг хийх;
- зөвлөх бүлэг зохион байгуулах;
- нээлттэй цаг зохион байгуулах;
- интернет ярилцлага зохион байгуулах гэх зэрэг олон ололт туршлага бий.

Үндэсний аюулгүй байдлын талаарх ойлголт, судлаачдын дүгнэлтээс үзвэл улс үндэстний язгуур ашиг сонирхол, амьдралын суурь хэрэгцээ зэрэг аюулгүй байдлыг хангах зорилгыг нөхцөлдүүлж буй зүйлс нь цар хүрээ, шинж чанарын хувьд хувь хүний, нийгмийн, төрийн түвшний гэж ангилагдаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү 3 түвшний амин чухал ашиг сонирхол, амьдрах, хөгжих, оршин тогтнох хэрэгцээний нэгдэл нь үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагааны зорилго, агуулгыг бий болгож буй үндсэн нөхцөл юм.

⁷Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

⁸Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Манай улсын хувьд улс төр, нийгмийн шинэ тогтолцоонд шилжсэн сүүлийн гучаад жилийн хугацаанд хүний нийгмийн аюулгүй байдлыг хангах талаар шууд болон шууд бус байдлаар Үндсэн хууль, бусад хууль, УИХ, Засгийн газраас батлан гаргасан шийдвэрүүд, үзэл баримтлал, хөтөлбөрүүдэд тусган эрх зүйн, төрийн байгууллын тогтолцоог бий болгох замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зэрэг бүхий л салбарыг хөгжүүлэх суурь алхамуудыг хийж ирсэн байна.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт улс орноо батлан хамгаалах бодлогын улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, эрх зүйн хийгээд мэдээллийн чиглэлийг тодорхойлж өгсөн нь батлан хамгаалах зорилт, үйл ажиллагаанд зөвхөн цэргийн төдийгүй улс орны улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, мэдээллийн бүх салаа мөчрийг хамарсан нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, зохицуулалтын цогц арга хэмжээ болохыг илэрхийлж байгаа бөгөөд үүгээр түүний ач холбогдол тодорхойлогдож байгаа⁹ бөгөөд нийгмийн чиглэлийн үндэс нь Монгол Улсын хүний хөгжлийн үндэс болж байгаа учраас манай улсын хувьд хүн амын эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, бие бялдрын хүмүүжлийг дээшлүүлэх нийт иргэд залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх нь улс орноо батлан хамгаалах төрийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байна.

Батлан хамгаалах үйл ажиллагаанд үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх, хууль дээдлэх, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх, орон нутгийн хамгаалалтад тулгуурласан байх, Зэвсэгт хүчин нь мэргэжлийн цэрэгт суурилсан байх, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоонд тулгуурлах, нэгдмэл харилцан уялдуулан зохицуулагдсан байх, шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлах, төрийн байгууллага, иргэн харилцанхариуцлага хүлээх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэх, нээлттэй байх зарчмыг¹⁰ баримтална гэсэн нь аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд иргэдийг оролцоог хангах хэлбэрийг тодруулж өгч байна.

Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг өргөжиж зөвхөн тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт түрэмгийллээс хамгаалаад зогсохгүй, олон улсын энхийг сахиулах, хүмүүнлэгийн болон иргэний хамгаалалтын ажиллагаанд оролцох, олон улсын терроризмтэй тэмцэх, далайн тээврийн аюулгүй байдлыг хамгаалах зэрэг олон талт үүрэг гүйцэтгэх

⁹БХЭШХ, “Батлан хамгаалах стратеги”, УБ., 2017, т-320.

¹⁰Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, 2016.

шаардлагатай болж байна. Аюулгүй байдлын энэхүү шинэ орчин нь нэг талаас Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын асуудлын судалгааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж болно.

§1.2. Батлан хамгаалах бодлого эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх шинжилгээ

1.2.1. Батлан хамгаалах бодлого эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодлын шинжилгээ

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно” гэжээ¹¹.

Мөн баримт бичигт зааснаар “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын зорилго нь аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс ангид байж, улсыг батлан хамгаалах тогтолцоо, батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг баталгаажуулах явдал мөн”¹².

Энэ бодлогын улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн чиглэлийн хэрэгжилтийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд зохион байгуулна. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна¹³ гэж заасан билээ.

Батлан хамгаалах салбарын дотоод, гадаад харилцаа ихээхэн өргөжиж, шинэ харилцаа, агуулгаар баяжин цэргийн алба хаагчид олон улсын энхийг сахиулах, хүмүүнлэгийн, сэргээн босгох ажиллагаа, бүс нутгийн аюулгүй байдлын олон талт арга хэмжээнд идэвхтэй оролцон, гадаад орнуудад олон чиглэлээр суралцаж, цэргийн албаны шинэ хэлбэрүүд бий болж, Зэвсэгт хүчин ардчилсан нийгмийн олон талт харилцаанд өргөнөөр оролцох болсон. Энэ нь батлан хамгаалах бодлого, түүнд эрхзүйн эзлэх байр суурь, үүрэг ролийг нэмэгдүүлэн, дэлхийн түвшний, олон улсын хэмжээнд мөрдөгддөг эрхзүйн шаардлага,

¹¹ Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” 1.1. заалт

¹² 1.2 заалт

¹³ 1.4 дэх заалт

хамгаалалт, үндэслэлийг эрхзүйдээ зөв тусган, мөрдлөг болгох шаардлагыг зүй ёсоор буй болгож байна.¹⁴

Нийгмийн харилцааг аливаа зүй бус хандлагаас хамгаалахад төр онцгой үүрэгтэй бөгөөд түүнд нь эрхзүй үйлчилж, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлогоо хэрэгжүүлэхэд шийдвэрлэх нөлөөг үзүүлж ирсэн. Батлан хамгаалахын хууль эрхийн актууд батлагдан гарснаар улс орныг батлан хамгаалах тогтолцоо, түүний удирдлага, Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг тодорхойлогдон баталгаажиж, түүнд тавих иргэний хяналтын үндэс бүрэлдэн буй болсон. Мөн төрийн захиргааны болон цэргийн мэргэжлийн удирдлагын зааг ялгааг тодотгон, цэргийн алба хаагчдын нийгэм, эрхзүйн баталгаа, эрхзүйн байдлыг хуульчилан баталгаажуулснаар тэдний үндсэн эрх, эрх чөлөөг хангах, тайван цагт ажил албаныхаа үүргийг аюулгүй орчинд гүйцэтгэх нөхцөл бүрдэж эхэлсэн.

Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчмын тулгуур заалтууд, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн биелэлтийг хангах, цэргийн алба хаагчид болон салбарын нийт албан хаагчдын төрийн хууль, төрт ёсоо эрхэмлэн дээдэлж, чанд сахих ухамсар, ёс зүй, хүмүүжлийг төлөвшүүлэх, салбарын харьяа анги байгууллага, цэргийн алба хаагчид, албан тушаалтны үйл ажиллагаа нь хуулиар зохицуулагдаж хамгаалагдсан, хуульд нийцсэн байх нөхцөл бүрдүүлэх, түүнийг боловсронгуй болгох нь Монгол Улсын Засгийн газрын эрхзүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх эрхзүйн бодлогын нэг зорилт болж байна.¹⁵ Иргэдээс гарах олон сайхан санаа байдаг, гагцхүү тэдгээрийг албан ёсны болгох, бусад иргэдээр дэмжүүлэхийн тулд тодорхой эрх зүйн механизм байх ёстой болж байна. Иргэдийн оролцоо гэдэг бол юун түрүүнд оролцох гэж байгаа иргэний ухамсар, хүсэл зоригоос ихээхэн хамааралтай. Иргэний ухамсар гэдэгт мэдлэг боловсрол, эрх зүйн болоод бусад шинжлэх ухааны талаар ерөнхий мэдлэг орно. Иргэний ухамсар (түүний дотор эрх зүйн ухамсар)-ыг төлөвшүүлэхэд төрийн байгууллагын үүрэг их юм.

Энэхүү судалгааны хүрээнд хувь хүний мэдээлэл болон батлан хамгаалах эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодлын мэдээллийг асуулга судалгааны аргаар цуглуулсан.

Судалгааны асуултууд нь хаалттай, хагас нээлттэй, нээлттэй асуултуудаас бүрдсэн болно. Судалгаанд оролцогчдын нас, хүйсний байдлыг 1, 2 дугаар зургаар

¹⁴Н.Бор, “Эрх зүй ба батлан хамгаалах бодлого” илтгэл, “Батлан хамгаалах бодлого (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийн эмхэтгэл)”, БХЭШХ, УБ., 2015, т-139.

¹⁵Мөн тэнд.

харуулав.



1 дүгээр зураг. Судалгаанд оролцогчдын нас (%-аар)



2 дугаар зураг. Судалгаанд оролцогчдын хүйс

Дээрх зургаас үзэхэд, судалгаанд оролцогчдоос эрэгтэй 54%, эмэгтэй оролцогч 46%, насны хувьд 18-28 насныхан 20.9%, 29-39 насныхан 26.9%, 40-50 насныхан 28.2%, 51-61 насныхан 15.3%, 61-ээс дээш насныхан 8.7% хамрагдсан байгаа нь дундаж насныхан голчлон оролцсон бөгөөд судалгаа үнэн зөв авагдах боломжийг хангана гэж үзэхээр байна.

Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхлэлтийн байдлыг хүйсээр ангилан харьцуулаж 1 дүгээр хүснэгтээр үзүүлээ.

1 дүгээр хүснэгт.


Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхлэлтийн байдлыг хүйсээр ангилан харуулсан хүснэгт

Боловсрол	Эрхэлдэг ажил						Бүгд	
	төрийн байгууллага	цэргийн байгууллага	хувийн хэвшил	оюутан	тэтгэвэрт	ажилгүй		
Дээд	Хүйс Эрэгтэй	29.4%	7.5%	10.7%	0.9%	0.9%	0.5%	50.0%
	Эмэгтэй	36.4%	2.8%	7.9%	0.9%	1.4%	0.5%	50.0%
	Бүгд	65.9%	10.3%	18.7%	1.9%	2.3%	0.9%	100.0%
Тусгай дунд	Хүйс Эрэгтэй	11.4%	0.0%	17.1%	2.9%	17.1%	5.7%	54.3%
	Эмэгтэй	14.3%	2.9%	20.0%	0.0%	8.6%	0.0%	45.7%
	Бүгд	25.7%	2.9%	37.1%	2.9%	25.7%	5.7%	100.0%
Бүрэн дунд	Хүйс Эрэгтэй	4.0%	2.0%	16.2%	26.3%	3.0%	9.1%	60.6%
	Эмэгтэй	0.0%	0.0%	5.1%	26.3%	3.0%	5.1%	39.4%
	Бүгд	4.0%	2.0%	21.2%	52.5%	6.1%	14.1%	100.0%

Бүрэн бус дунд	Хүйс	Эрэгтэй			18.2%		9.1%	36.4%	63.6%
		Эмэгтэй			18.2%		9.1%	9.1%	36.4%
	Бүгд			36.4%		18.2%	45.5%	100.0%	
Бага	Хүйс	Эрэгтэй			50.0%			50.0%	100.0%
		Эмэгтэй							
	Бүгд			50.0%			50.0%	100.0%	
Боловсролгүй	Хүйс	Эрэгтэй					100.0%	100.0%	
		Эмэгтэй							
	Бүгд						100.0%	100.0%	
БҮГД			42.5%	6.9%	21.8%	15.7%	6.1%	6.9%	100.0%

Судалгаанд оролцогчдын 42.5 хувь нь төрийн байгууллагад, 6.9 хувь нь цэргийн байгууллагад, 21.8 хувь нь хувийн хэвшилд, 15.7 хувь нь оюутан, 6.1 хувь нь тэтгэвэрийн ахмад насныхан, 6.9 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй хүмүүс ч байлаа.

Та Батлан хамгаалахтай холбоотой дараах хууль, эрх зүйн баримт бичгийн талаарх өөрийн мэдлэгээ хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултын хариултаас доорх үр дүн харагдаж байгааг 3 дугаар зургаар харуулав.



3 дугаар зураг. Та Батлан хамгаалахтай холбоотой дараах хууль, эрх зүйн баримт бичгийн талаарх өөрийн мэдлэгээ хэрхэн үнэлэх вэ?

Судалгаанд оролцогчид бүхий л хуулийн тухайд өөрийн мэдлэгээ дунд зэрэг гэж үнэлсэн байдал ажиглагдаж байгаа бөгөөд “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”, “Батлан хамгаалах тухай хууль”-д өөрийн мэдлэгээ хангалтгүй гэсэн үнэлгээг илүү өгсөн тал ажиглагдаж байгаа нь эдгээр хуулиуд харьцангуй сүүлд шинэчлэгдэн батлагдсантай холбоотой байж болох талтай.

Харин нийт дүнгээр дундаж үнэлгээ их байгаа учраас цэргийн алба хаагчдын хувьд ямар байхыг үзэхээр эрхэлдэг ажилтай нь харьцуулан 2 дугаар хүснэгтээр үзүүлээ.


2 дугаар хүснэгт.

Цэргийн алба хаагчдын хувьд ямар байхыг үзэх зорилгоор эрхэлдэг ажилтай нь харьцуулан гаргасан хүснэгт

Эрхэлдэг ажил	Өөрийн үнэлгээ	БХ бодлогын үндэс	БХ тухай хууль	ЗХ-ний тухай хууль	Цэргийн албаны тухай хууль	ЦАХ-дын эрхзүйн байдлын тухай хууль	Дайчилгааны тухай хууль	Орон нутгийн хамгаалалтын тухай хууль
Төрийн байгууллага	Хангалттай	14%	18%	18%	16%	11%	15%	14%
	Дунд зэрэг	50%	43%	44%	52%	51%	41%	44%
	Хангалтгүй	36%	39%	38%	32%	38%	45%	42%
Цэргийн байгууллага	Хангалттай	24%	28%	24%	28%	16%	13%	26%
	Дунд зэрэг	48%	36%	40%	44%	72%	61%	48%
	Хангалтгүй	28%	36%	36%	28%	12%	26%	26%
Хувийн хэвшил	Хангалттай	19%	23%	23%	23%	15%	21%	13%
	Дунд зэрэг	49%	40%	42%	45%	51%	54%	45%
	Хангалтгүй	31%	36%	35%	31%	35%	25%	41%
Оюутан	Хангалттай	16%	20%	21%	23%	19%	14%	18%
	Дунд зэрэг	57%	52%	57%	55%	53%	66%	50%
	Хангалтгүй	27%	29%	21%	21%	28%	20%	32%
Тэтгэвэрт	Хангалттай	0%	10%	5%	14%	5%	0%	0%
	Дунд зэрэг	57%	48%	52%	48%	71%	57%	70%
	Хангалтгүй	43%	43%	43%	38%	24%	43%	30%
Ажилгүй	Хангалттай	12%	17%	12%	12%	19%	10%	14%
	Дунд зэрэг	48%	25%	29%	46%	38%	43%	45%
	Хангалтгүй	40%	58%	58%	42%	43%	48%	41%

Энэ хүснэгтээс үзэхэд, цэргийн байгууллагад ажилладаг оролцогчдын “хангалттай” гэсэн үнэлгээ нь асуулгад дурдагдсан бүх хуулийн хувьд бусад ажил эрхлэгчдээс илүү буюу “БХ бодлогын үндэс”-24%, Батлан хамгаалах тухай-28%, Зэвсэгт хүчний тухай-24%, Цэргийн албаны тухай-28%, Орон нутгийн хамгаалалтын тухай-26% нь хангалттай гэж хариулсан байна. Тэгвэл хувийн хэвшилд ажиллагчдын Дайчилгааны тухай хуулийн мэдлэгээ хангалттай-23%, дунд зэрэг-54% гэж үнэлсэн байгаагаас үзэхэд дайчилгааны сургалт бэлтгэлийн үед хамрагдан өөрсдийн хэрэгцээт хуулийг судлан үздэгтэй холбон тайлбарлаж болно.

Батлан хамгаалах багц эдгээр хуулиудын хэрэгжилтийг тодруулах зорилгоор “Эдгээр хуулиуд нь таны ажил, амьдралтай хэр хамааралтай гэж боддог вэ?” гэсэн асуултад хэрхэн харуулсан байдлыг 4 дүгээр зургаар харуулав.



4 дүгээр зураг. Батлан хамгаалах багц хуулиудын хэрэгжилтийг тодруулах зорилгоор “Эдгээр хуулиуд нь таны ажил, амьдралтай хэр хамааралтай гэж боддог вэ?” гэсэн асуултад хэрхэн харуулсан байдал

Дээрх үр дүнгээс харахад тодорхой хэмжээнд хамааралтай гэсэн хариулт бүх хуулиудад дундаас дээш хувь эзэлж байна. Ялангуяа Батлан хамгаалах бодлогын үндэс-61%, Цэргийн албаны тухай хууль-59%, Батлан хамгаалах тухай хууль-58%-тай байна. Харин хамааралтай гэсэн хариулт Орон нутгийн тухай хууль-30%, Цэргийн албаны тухай хууль-30% буюу бусдаас илүү дүнтэй харагдаж байна.

Батлан хамгаалах багц хууль эрх зүйн баримт бичгүүдийг судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлыг харьцуулан 3 дугаар хүснэгтээр харуулав.

3 дугаар хүснэгт

Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал

Эрхэлдэг ажил	Хамааралтай байдал	БХ бодлогын үндэс	БХ тухай хууль	ЗХ-ний тухай хууль	Цэргийн албаны тухай хууль	ЦАХ-дын эрхзүйн байдлын тухай хууль	Дайчилгааны тухай хууль	Орон нутгийн хамгаалалтын тухай хууль
Төрийн байгууллага	Их хамааралтай	20%	25%	27%	30%	27%	27%	32%
	Тодорхой хэмжээнд хамааралтай	66%	61%	56%	56%	60%	61%	60%
	Хамааралгүй	14%	14%	17%	14%	14%	12%	8%
Цэргийн байгууллага	Их хамааралтай	20%	16%	25%	25%	20%	28%	28%
	Тодорхой хэмжээнд хамааралтай	64%	56%	54%	54%	60%	48%	36%

	Хамаарал гүй	16%	28%	21%	21%	20%	24%	36%
Хувийн хэвшил	Их хамааралтай	14%	14%	13%	13%	14%	12%	21%
	Тодорхой хэмжээнд хамааралтай	61%	61%	60%	58%	63%	60%	54%
	Хамаарал гүй	25%	25%	27%	29%	23%	29%	25%
Оюутан	Их хамааралтай	25%	21%	18%	30%	19%	23%	41%
	Тодорхой хэмжээнд хамааралтай	57%	59%	56%	48%	54%	61%	41%
	Хамаарал гүй	18%	20%	25%	21%	27%	16%	18%
Тэтгэвэрт	Их хамааралтай	15%	5%	10%	9%	5%	5%	9%
	Тодорхой хэмжээнд хамааралтай	50%	55%	42%	52%	48%	52%	50%
	Хамаарал гүй	35%	40%	47%	38%	48%	43%	41%
Ажилгүй	Их хамааралтай	25%	21%	17%	25%	29%	17%	40%
	Тодорхой хэмжээнд хамааралтай	46%	38%	42%	33%	33%	42%	32%
	Хамаарал гүй	29%	42%	42%	42%	38%	43%	28%

Ажил эрхлэлттэй хамааралтай байдлаас харахад төрийн болон цэргийн байгууллагын албан хаагчдын “тодорхой хэмжээнд хамааралтай” гэсэн хариулт бусад салбарын ажилтнуудын хариулттай харьцуулахад харьцангуй илүү буюу Батлан хамгаалах бодлого-66%, Батлан хамгаалах тухай хууль-61%, Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль-60%, Дайчилгааны тухай хууль-61%, Орон нутгийн тухай хууль-60% хувь байгаа ажиглагдлаа.


Эдгээр хуулиас гадна төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнд тавих хяналтыг сайжруулж, хариуцсан ажил, үйлчилгээ, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулсан албан хаагчид хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагыг хангахаар ТАТХ-ийн шинэчилсэн найруулгад орсон байна. Эдгээртэй уялдуулан дүгнэвэл хууль эрхзүйн хариуцлагын тогтолцоог бодитоор хэрэгжүүлэхийн тулд хариуцсан эрх бүхий байгууллагад хуульд заасан хэлбэрээр нөлөөлөх, хариуцлагын тогтолцооны үр нөлөөг сурталчлан таниулах, ажил хариуцсан албан тушаалтнуудыг сургах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” хэмээх Хоёрдугаар бүлэгт тусгагдсан хүний суурь болон үндсэн эрхүүдийг төр хангах үүрэгтэй боловч эдгээр үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлахыг зөвшөөрдөг. Мөн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн төрд үүссэн хохирлыг барагдуулах үзэл санаа нь 2019 оноос хэрэгжиж эхлэх Төрийн албаны хуулийн /шинэчилсэн найруулга/ мөн тусгалаа олсон явдал нь төрийн албан тушаалтан, тэр дундаа нийтийн эрх зүйн этгээд болох захиргааны байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны хариуцлагыг чангатгахад чиглэсэн, олон нийтийн хяналтын үүргийг баталгаажуулсан хуулийн зохицуулалт болсон байна.

Батлан хамгаалах салбарын нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санаа бодлын шинжилгээний хэсгээс доорх үр дүн ажиглагдлаа.

Та манай улс батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчиндээ хэр зэрэг төсөв, мөнгө зарцуулдаг гэж боддог вэ? гэсэн асуултад 4.5% нь хэт их, 25% нь хангалттай, 29% нь хэт бага, 42% нь мэдэхгүй гэж хариулснаас үзвэл Батлан хамгаалах салбарын талаарх иргэдийн сонирхол, оролцоо төдийлөн сайнгүй гэж дүгнэж болох бөгөөд энэхүү асуултыг Та Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, иргэн-цэргийн харилцаа өнөөдөр ямар түвшинд байна гэж бодож байна вэ? асуултад 6% нь маш сайн, 19% нь сайн, 39% нь дунд, 13% муу, 4% нь маш муу, 18% нь мэдэхгүй гэж хариулсан байдалтай харьцуулан үзвэл иргэн-цэргийн харилцааны гол асуудлуудын нэг болох Зэвсэгт хүчинд хэрэгжүүлэх иргэний хяналтыг цэргийн байгууллагыг байнга хардах, хянах гэсэн утгаар бус харин цэргийн болон иргэний удирдлага харилцан бие биенээ нөхсөн хамтын ажиллагаагаар үйл ажиллагаагаа явуулж, улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт түрэмгийллээс хамгаалах, байгалийн гамшиг, дотоодын дэг журам алдагдсан үед иргэний удирдлагад захирагдан орон нутгийн удирдлага, иргэний цагдаа, тагнуулын байгууллагыг дэмжин ажиллах, олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд хувь нэмрээ оруулах, энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох, байлдааны хүчин чадавхиа байнга нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд үндсэн зорилго, зорилтоо чиглүүлэх учиртай болж байна.

Монгол Улсын аюулгүй байдлын талаарх таны ойлголт ямар түвшинд байдаг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын хариуултын байдлыг 5 дугаар зургаар үзүүлэв.



5 дугаар зураг. Монгол Улсын аюулгүй байдлын талаарх таны ойлголт ямар түвшинд байдаг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын хариултын байдал

Монгол Улсын аюулгүй байдлын талаарх таны ойлголт ямар түвшинд байдаг вэ? гэсэн асуултад 16% нь сайн, 56% нь дунд, 23% нь муу, 6% нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд харин Таны бодлоор манай улсад доорх аюулгүй байдлын орчин хэрхэн хангагдсан гэж үзэж байна вэ? гэсэн асуултад хариулсан байдлаас үзэхэд, хүнсний аюулгүй байдал муу-47%, Эдийн засгийн аюулгүй байдал муу-46%, Мэдээллийн аюулгүй байдал муу-46%-тай байгаа нь анхаарал татаж байна. Эдийн засгийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гол тулгуур юм. Өнөөгийн глобалчлагдсан ертөнцөд аюулгүй байдалд шинэ, олон төрлийн эрсдэл үүсэн бий болж байна.

Улс, үндэстнүүд хоорондоо улам өргөн харилцах болж, даяаршин эдийн засаг, нийгмийн нэгдмэл орчинг бий болгон, мэдээлэл, холбооны хэрэгслээр холбогдон, хил хязгааргүй гэхээр шинэ орчинд амьдрах болсон. Энэ шинэ орчин нь хөгжил, дэвшлийг нээж өгөхөөс гадна шинэ аюул, занал, эрсдэлийг бий болгож байгаа¹⁶ талаарх эрдэмтдийн судалгааг анхаарах хэрэгтэй юм. Хүнсний аюулгүй байдлын хувьд хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг хэлдэг.

Монгол орны хувьд хүнсний аюулгүй байдлын хяналтыг хийхдээ хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах хорт бодис микотоксин, пестицид, хүнд металлын үлдэгдэл, химийн бодисын үлдэгдэл, эмийн бодисын үлдэгдэл болон цацрагийн бохирдлуудыг тодорхойлоход дэвшилтэт технологийг ашиглах үйл ажиллагаа сул

¹⁶Alan M.Wachman Mongolia's Geopolitical Gambit:Preserving a Precarious Independence While Resisting "Soft Colonialism", 2009,Tufts University.

байгааг мэргэжлийн шинжээчид онцолсон байдаг. Мэдээллийн аюулгүй байдлын хувьд ямар ч байгууллагын үйл ажиллагаа, ажил хэргээ хэвийн явуулахад шаардагдах гол хөрөнгө учраас нууцлагдсан ба хамгаалагдсан байна. Иймээс мэдээллийн аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, байгууллага, хуулийн этгээд дотоод дүрэм журам, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллах, дүрэм журам стандартыг мөрдөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрөл бүрийн шатлалын болон хугацааны сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа шаардлагатай юм.

1.2.2. БХЯ-ны бодлого, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээ

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг үнэлж дүгнэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” –ыг баримтлан хийсэн болно.

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг үнэлэхдээ *нэгд*, Батлан хамгаалахын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд, *хоёрт*, Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд, *гуравт*, Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд, *дөрөвт*, Үлсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх хүрээнд, *тавд*. Батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг дэмжих ажиллагаан дахь Зэвсэгт хүчний оролцоог өргөжүүлэх хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал гэсэн байдлаар үнэлгээ хийлээ.

***Нэгдүгээрт*. Батлан хамгаалахын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:**

1990-ээд оноос эхтэй батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийн хоёр дахь давалгаа 2015 онд Улсын Их Хурлаар “Монгол- Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг батлагдсанаар эрчимжиж 2016-2020 онд дараах 4 үндсэн гол багц хуулиудыг батлуулсан байна. Үүнд:

1. Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
2. Зэвсэгт хүчний тухай хууль /шинэчилсэн найруулга/;
3. Цэргийн албаны тухай хууль;
4. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль байна.

Мөн дараах 6 хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Үүнд:

1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
2. Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
3. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль /анхдагч/;
4. Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
5. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
6. Зэвсэгт хучний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

Батлан хамгаалахын багц хууль батлагдсанаар хүрч буй гол үр дүн:

1. Батлан хамгаалахын багц хууль батлагдсанаар Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндэс шинэчлэгдэж, төрийн цэргийн байгууллын тогтолцоо, Зэвсэгт хучний бүтэц цинээр тодорхойлогдож, Монгол Улсын иргэн хуулийн дагуу цэргийн алба хаах эрх зүйн харилцаа боловсронгуй болж, цэргийн алба хаагчийн эрхзүйн баталгаа дээшилсэн.
2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар цэргийн алба хаагч иргэний байгууллагад ажилласан жилээ цэргийн байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцуулж, тэтгэврээ нэмэгдүүлэх боломжтой болсон байна.
3. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар цэргийн анги, байгууллагын эмнэлгийн энгийн эмч, ажилтан, алба хаагч нар нэг удаагмйн мөнгөн тэтгэмж авах эрх зүйн баталгаа хангагдсан юм.
4. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль батлагдсанаар иргэний "Эх орноо хамгаалах" Үндсэн Хуулийн заалт хэрэгжих, орон нутгийн хамгаалалтын талаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн уялдаа холбоо, батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны цогц байдал хангагдах үндэс суурь тавигдсан байна.
5. Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар Монгол Улсын Зэвсэгт хүчин түүхэн хөгжлийнхөө явцад урьд байгаагүйгээр өргөжин хөгжих эрх зүйн зохицуулалттай болжээ. Ингэснээр Зэвсэгт хүчин нь хуурай замын цэрэг, агаарын цэрэг, барилга-инженерийн цэрэг, кибер аюулгүй байдлын цэрэг болон тусгай хүчний цэргээс бүрдэхээр хуульчлагдсан байна.

6. Дээрх хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн түвшинд 5 дүрэм, журам, Засгийн газрын түвшинд 14 журмыг баталгаажуулан хэрэгжүүлж байна.

Хоёрдугаарт. Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:

Батлан хамгаалах яамыг бэхжүүлэх талаар дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. 2016 онд Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулиар Батлан хамгаалах яамыг Ерөнхий чиг үүргийн яам байхаар хуульчлан тогтоосон. Төрийн батлан хамгаалах бодлогод тодорхойлсны дагуу батлан хамгаалах үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн цогц арга хэмжээ болохын хувьд батлан хамгаалах асуудаг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг Ерөнхий чиг үүргийн болгон хуульчлан бататгаснаар төр, засаг, бүх шатны төрийн байгууллага, ард иргэдийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх нөхцөлийг хангасан байна.
2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг Ерөнхий чиг үүргийн болгосноор Батлан хамгаалах яамны бүтэц, орон тоог бэхжүүлж, 2016 онд 5 газар, 2 хэлтэс, 55 алба хаагчтай байсныг өргөжүүлэн өнөөгийн байдлаар 5 газар, 6 хэлтэс, 1 алба, 75 алба хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

"Мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчинтэй болох" бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050" баримт бичиг УИХ-ын чуулганаар батлагдлаа. Уг баримт бичигт "Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, чадавхыг бэхжүүлэх" зорилт дэвшүүлж, энэ зорилтын хүрээнд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх 15 үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоод байна. Уг зорилт хэрэгжсэнээр 2050 онд батлан хамгаалах тогтолцоо төгөлдөржиж, батлан хамгаалах аж үйлдвэрлэл хөгжиж, нэгдмэл тогтолцоотой, технологижсон, өндөр чадамжтай Зэвсэгт хүчинтэй болсон байна.

2. "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" баримт бичгийг Засгийн газрын тогтоолоор баталгаажуулжээ.
3. Энэхүү стратеги нь дэлхий нийтийн болон Монгол Улсын өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудалтай уялдуулан төрийн цэргийн байгууллагуудын хөгжлийн зорилго, зорилт, тэдгээрийн хэрэгжилтийг хангах арга замыг анх удаа нэгтгэн тодорхойлсон урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болсон юм.
4. "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг Засгийн газрын тогтоолоор баталгаажуулж, хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Зэвсэгт хүчний эрх зүйн орчин шинэчлэгдэж, тайван цагийн бүтэц, орон тооны хүч хэрэгслээрээ хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх анги, салбар нэмэгдэж, тэдгээрийн бэлэн байдал, чадавхын түвшин дээшилж, цаашид мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх үндэс суурийг тавиад байна.
5. "Төрийн цэргийн номлол" баримт бичгийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр батлуулжээ. Уг баримт бичигт Монгол Улс өөрийгөө хамгаалах үзэл баримтлалд нийцүүлэн тайван болон дайны цагт Зэвсэгт хүчнийг ашиглах үндэс, арга, хэлбэрийг тодорхойлжээ.
6. Зэвсэгт хүчний төрлийн цэргийг бие даалгах, хөгжүүлэх ажлыг эхлүүлжээ. 2016 онд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн болон Агаарын цэргийн командлалыг Засгийн газрын шийдвэрээр байгуулж, 2019 онд Хуурай замын цэргийн командлалыг Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт шилжүүлэн байрлуулж, бие даасан байдлыг нь хангасан байна. Цаашид Агаарын цэргийн командлалыг бие даалган хөгжүүлэх асуудал шийдвэрлэгдэх шатандаа явж байна. Засгийн газрын шийдвэрээр Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлын төвийг байгуулжээ. Энэхүү төвийг байгуулснаар Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах, гадны кибер халдлагаас хамгаалах, хариу арга хэмжээ авах зохион байгуулалтын болон техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах үндэс суурь тавигджээ. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүүхэд, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, бахархах үндэсний ухамсрыг төлөвшүүлэх, улс орноо хөгжүүлэхэд тэдний оролцоо, хариуцлагыг дээшлүүлэхэд тодорхой ахиц гарахаар байна.

7. Дайчилгааны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу Орхон аймагт дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийг амжилттай зохион байгуулан явуулсан байна. Энэ сургуулийн ажиллагаанд Монгол Улсын ерөнхий сайд У.Хүрэлсүх оролцож өндрөөр үнэлсэн байна.
8. 2016-2020 онд 3900 орчим оюутан залуус "Оюутан-цэрэг" сургалтад хамрагдаж, Үндсэн хуулиар хүлээсэн цэргийн алба хаах үүргээ бмелүүлж, цэргийн мэргэжил эзэмшин нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдээд байна. Оюутан залуус "Оюутан-цэрэг" сургалтад хамрагдсанаар цэрэг-эх оронч үзэлтэй, эрүүл чийрэг бие бялдартай, эх орноо батлан хамгаалах сэтгэл зүйн бэлтгэлтэй болон төлөвшихийн зэрэгцээ их, дээд сургуулиа төгсөөд төрийн албанд орж ажиллах нэг шалгуур үзүүлэлтийг хангах боломж бүрдэж байгаа юм. "Улсын батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон тусгай хэрэгцээний газрын жагсаалт"-ыг Улсын Их Хурлаар, "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, байгууллагын тусгай хэрэгцээний газрын хориотой бүс тогтоох журам"-ыг Засгийн газрын тогтоолоор тус тус батлуулжээ. Ингэснээр цэргийн ангийн байрлал болон хээрийн сургалтын төвийн газрын асуудал шийдвэрлэгдсэн байна.
9. Батлан хамгаалах бодлого, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан Зэвсэгт хүчний тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг бэлтгэн хөгжүүлэх үүднээс Батлан хамгаалахын сайдын шийдвэрээр "Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого" баримт бичиг "Цэргийн мэргэжлийн боловсролын шаталсан сургалтын тогтоцоо"-г тустус баталжээ.
10. Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэрэг МИГ-29 загварын сөнөөгч онгоцтой болсон байна. Монгол Улс, ОХУ-ын Батлан хамгаалах салбарын цэрэг-техникмйн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэгдсэн энэхүү асуудал нь Монгол Улсын агаарын орон зай, агаарын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах чадавхыг нэмэгдүүлсэн ач холбогдолтой болжээ.

Гуравдугаарт, Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:

1. Засгийн газрын шийдвэрээр албан тушаалын зарим орон сууцыг үнэгүй хувьчиллаа. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд алба хааж буй офицер, ахпагч нарын нийгмийн баталгааг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт байрлах 19, 20, 21,

- 22 дугаар байрны нийт 91 айлын орон сууц, нийслэл Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсэрт байрлах 29 айлын орон сууцыг амьдарч байгаа офицер, ахлагч, ахмад дайчдад үнэгүй хувьчилсан байна.
2. Албан тушаалын 563 айлын орон сууцыг оршин сууж байгаа офицер, ахлагч нарт хөнгөлттэй үнээр худалдан шилжүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргасан байна. Үүндээ орон сууцны үнийг өнөөгийн зах зээлийн үнэ ханшаас 30-50 хувиар бага байхаар тогтоон, хувьчлах ажлыг хэрэгжүүлжээ.
 3. 2016-2020 онд 153 офицер, ахлагч, ахмад дайчдад орон сууц, гэр, байшин худалдан авахад нь зориулж 500 орчим сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлжээ.
 4. Батлан хамгааяах салбарт алба хааж байгаа бие бүрэлдэхүүнийг албан тушаалын орон сууцаар хангах, гэр олгох, эдэлбэр газартай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж 2016 онд 12 алба хаагч, 2017 онд 120 алба хаагч, 2019 онд 16 алба хаагч, 2020 онд 30 алба хаагч, нийт 178 цэргийн алба хаагчийг албан тушаалын орон сууцаар хангаад байна.
 5. 2018 онд Засгийн газрын шийдвэрээр "Зэвсэгт хүчний алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалт"-ыг шинэчлэн тогтоосноор тухайн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нэмэгдэл, хөнгөлөлт, тусламжийг авах нөхцөлийг бүрдүүлжээ.
 6. Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2016 онд гадаадын 15 оронд 503, 2017 онд 533, 2018 онд гадаадын 14 оронд 475, 2019 онд 271, нийт 1782 цэргийн алба хаагчийг суралцуулж, мэдлэг боловсролыг нь дээшлүүлсэн байна.
 7. "Цэргийн алба хаагчийн гэр бүлмйн гишүүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулснаар офицер, ахлагч нарын гэр бүлийн гишүүд Цэргийн төв эмнэлэг болон цэргийн ангийн эмнэлэгт хандан эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах боломжтой болжээ.
 8. Батлан хамгаалах яам, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, цэргийн ангид ажиллаж байгаа алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд Батлан хамгаалах яамны дэргэд 120 хүүхдийн "Цоглог" цэцэрлэгийг байгуулж, 2018 оноос үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

9. 2016-2020 онд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран 15 мэргэжлээр 2000 орчим хугацаат болон цэргийн гэрээт алба хаагчийг сургалтад хамруулж, хос мэргэжил эзэмшүүлээд байна.
10. Аугаа их Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 3 дугаар багийн өндөр настан, ахмад дайчин Сүрэнхорын Цэгмид гуайд "Байлдаанд оролцогчийн үнэмлэх"-ийг олгож, 1,000,000.00 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлжээ. Тэрээр 1942 онд Зөвлөлтийн улаан армид "Хувьсгалт Монгол" танкийн цувааг фронтод хүргэх Монголын ард түмний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтаж, дайны гал асч байсан Свердловскийн фронтод хүрч Монголын ард түмний бэлгийг гардуулж явсан түүхэн гавьяатай нэгэн юм. Малчин өндөр настан, ахмад дайчин Сүрэнхорын Цэгмид нь Монгол Улсын малчин цол, тэмдгээр шагнагдсан байна.

Дөрөв. Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:

1. Барилга-инженерийн цэргийн үндэс суурийг шинээр тавих ажил 2010 оноос эхэлж Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын зүгээс сүүлийн 10 гаруй жилд барилга-инженерийн 6 анги байгуулах асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлснээс 338, 339, 340, 110 дугаар барилга-инженерийн ангиуд байгуулагдан үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.
2. 2016-2020 онд барилга-инженерийн ангиуд Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн сургалтын төвийн 400 цэргийн байр, Зэвсэгт хүчний 339, 340 дүгээр ангийн алба хаагчдын 40 айлын орон сууц, Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн харьяа халдвартын эмнэлгийн байр, Зэвсэгт хүчний 120, 123, 311, 353 дугаар ангийн соёл, спортын төв, Баян-Өлгий аймгийн Тагуулын газрын барилга зэрэг бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг хийж гүйцэтгээд байна.
3. 2019 оноос Засгийн газрын шийдвэрээр ЗХЖШ-ын бүтцэд бүтээн байгуулалтын асуудал хариуцсан нэгжийг бий болгон ажиллуулснаар цэргийн барилга-инженерийн анги, салбаруудын техник, тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөцийн чадавх, удирдлага, зохион байгуулалт эрс дээшилж бодитой үр дүнд хүрчээ.

4. Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд дээрхээс гадна улс орны стратегийн томоохон бүтэи байгуулалтын ажилд голлох үүрэгтэй оролцож байна. Тухайлбал:

1. Газрын тос боловсруулах үйлдвэрийн авто замын барилгын ажил:

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн 17,5 км хүнд даацын авто зэм барих ажлыг богино хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн байна.

2. Хуурай замын цэргийн командлалын барилгын ажил:

Засгийн газрын 2018 оны шийдвэрээр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалыг Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт шилжүүлэх болсонтой холбогдуулан тус командлалын штаб, бусад барилга бэйгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг Зэвсэгт хүчний 017 дугаар анги богино хугацаанд гүйцэтгэн ашиглалтад оруулжээ.

3. Дорнод аймгийн Халх гол суманд "Шинэ сум" төслийн бүтээн байгуулалтын ажил:

Зэвсэгт хүчний барилга-инженерийн 110, 338 дугаар ангиуд Дорнод аймгийн Халх гол сумын "Шинэ сум" төслийн бүтээн байгуулалтын ажилд оролцлоо. Тус бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний 184 алба хаагч, 16 нэгж техниктэйгээр оролцож, эмнэлэг, сургууль, дотуур байр, цэцэрлэг, спорт заал, урлагийн заалны барилгын ажлыг чанартай гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

4.Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414,6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажил:

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр, "Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрлийн дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414,6 км төмөр замын суурь, гүүр, хоолойн ажмл болон өртөө, зөрлөгийн барилгыг Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд барьж, байгуулж байна.

Тав. Батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг дэмжих ажиллагаан дахь Зэвсэгт хүчний оролцоог өргөжүүлэх хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:

Монгол Упсын аюулгүй байдлыг цэрэг-улс төр, дипломатын аргаар хангах бодлогын хүрээнд батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, өнөөдрийн байдлаар 37 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон, хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Үүнээс 5 улстай /ОХУ, БНХАУ, Украины, Беларусь, Турк/ нь цэрэг-техникийн хамтын ажиллагаатай байна.

2016-2020 онд батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааны хүрээнд дараах гэрээ, хэлэлцээрийг байгуулсан байна. Үүнд:

1. ОХУ-тай Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үйлчлэлийг сэргээх тухай Засгийн газар хоорондын протокол;
2. БНИталиУ, БНСБУ, БНТУ зэрэг улстай батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр;
3. БНЧехУ-тай "Батлан хамгаалах яам хоорондын техникийн тохиролцоо";
4. Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиглагааны хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн нэмэлт гэрээ;
5. АНУ-тай "Цэргийн алба хаагчид, тэдний гэр булийн гишүүдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх тухай БХЯ хоорондын хэлэлцээр; "АНУ-ын АЦХ болон Монгол Улсын Зэвсэгт хүчний хооронд байгуулах агаарын цэргийн удирдагчийг бэлтгэх хөтөлбөрийн гэрээ";
6. "БНХАУ-ын БХЯ-наас Монгол Улсын БХЯ-нд цэргийн буцалтгүй тусламж олгох тухай хэлэлцээр".
7. Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдал, хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, түүний хэрэгжилт, цаашдын төлөв, чиг хандлагын талаар харилцан ярилцаж, санал солшцох, шийдвэр гаргах зорилгоор 10 улс /ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГҮ, БНСУ, Япон, Их Британи, Австрали, БНТУ, БНЭУ/, нэг олон улсын байгууллага /НАТО/-тай Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг 2016-2020 онд амжилттай зохион байгуулжээ.
8. Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд гадаад улсад суугаа болон гадаад улсаас манам улсад суугаа цэргийн атташегийн алба онцгой үүрэгтэй ажилладаг. Атташегийн албыг өргөжүүлэх арга хэмжээний хүрээнд 2017 онд Япон Улсаас манай улсад суух Батлан хамгаалахын атташегшн алба, 2019 онд

БНТУ болон Япон Улсад манай улсаас суух цэргийн атташегийн албаны асуудлыг шийдвэрлэж, үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

9. 2016-2020 онд Батлан хамгаалахын сайд Монгол Улстай стратегийн иж бүрэн, стратегийн түншлэлийн харилцаатай болон бүс нутгийн орнуудын Батлан хамгаалахын сайд нартай хийх уулзалтыг нэмэгдүүлж, батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тодорхой хувь нэмрийг оруулсан Тухайлбал, Батлан хамгаалахын самд ОХУ, БНХАУ, АНУ, Герман, Япон, БНСУ, Турк, Вьетнам, Энэтхэг Улсад албан ёсны айлчлал хийсэн байна.
10. Батлан хамгаалахын сайдын урилгаар 2018, 2019 онд ОХУ-ын Батлан хамгаалахын сайд, дэд сайд, АНУ, ХБНГУ-ын Батлан хамгаалахын сайд нарын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал нь хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан хэмээн талууд санал нэгтэй дүгнэсэн байна.
11. 2016-2020 онд АНУ, БНТУ, БНХАУ, ХБНГУ-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хурээнд дараах техник, материал хэрэгслийг буцалтгүй тусламжаар авчээ. Үүнд:
 - ОХУ-аас Налайх дахь цэргийн нисэх буудалд шаардлагатай нийт 13,4 сая ам.долларын үнэ бүхий техник, тоног төхөөрөмж;
 - БНХАУ-аас 58 сая юанийн үнэ бүхий техник, тоног, төхөөрөмж;
 - АНУ-аас нийт 4,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий инженерийн техник, хэрэгсэл, 5,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий цэргийн хээрийн II шатны эмнэлэг;
 - ХБНГУ-аас 1,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий Мерседес Бенц Больф 0-250 загварын автомашинууд зэрэг байна.
12. Чөлөөлөх дайны 75 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэж, ахмад дайчдыг шагнаж урамшуулсан байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 оноос хойших 18 жилийн хугацаанд НҮБ-ын энхийг сахиулах болон эвслийн цэргийн ажиллагаанд давхардсан тоогоор нийт 18000 гаруй цэргийн алба хаагч оролцож, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, даян дэлхийн энх тайван, бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулсаар байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар БНӨСУ, БНСУ-ын Дарфур, Абей муж, ИБНАУ, Баруун Сахар, БНАКонгоУ, Йемэн зэрэг 7 улсын нутаг дэвсгэрт явагдаж буй энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс нийт 1100 гаруй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй биелүүлж байна.

2019 оны 3 дугаар сард болсон НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээгч орнуудын Батлан хамгаалахын сайд нарын бага хуралд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд оролцож, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Энхийг сахиулах ажиллагааны асуудал хариуцсан орлогч дарга нартай уулзаж, Монгол Улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох цаашдын бодлого, чиглэл, байр суурийн талаар харилцан санал солилцсон байна.

Мөн ХБНГУ-ын Холбооны батлан хамгаалахын сайдын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр талууд "Шийдвэртэй дэмжлэг" ажмллагааны техникийн тохиролцоог шинэчлэн гарын үсэг зурсан нь манай улсын ИБНАУ-д явагдаж буй энхийг дэмжих ажиллагаан дахь оролцоогоо хадгалах ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж үнэлгээг дараах аргачлалаар тооцлоо:

“Бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

“Хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, хөрөнгө санхүүтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

“Хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

“Хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил боловсруулалтын шатанд байгаа, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);

”Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

Бодлогын зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно. Тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж хувиар илэрхийлнэ.

Үүнийг дараах томъёогоор бодно.

$$B = \frac{1}{n} \left(\sum_{i=1}^n \frac{X_i}{Z_i} \right) \times 100\%$$

B - бодлогын зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүн;

X - арга хэмжээ, зүйл заалтын хүрсэн түвшин;

Z - арга хэмжээ, зүйл заалтын зорилтот түвшин;

n - арга хэмжээ, зүйл заалтын тоо;

i - үзүүлэлтийн дугаар;

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг үнэлсэн байдлыг 4 дүгээр хүснэгтээр үзүүлэв.

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг үнэлсэн байдал

4 дүгээр хүснэгт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтууд	Тавьсан зорилт арга хэмжээний тоо	Биелэсэн арга хэмжээний тоо	Арга хэмжээний чанар
1.	<i>Нэгдүгээрт.</i> Батлан хамгаалахын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:	29	29	4 үндсэн гол багц хуулиудыг батлуулсан байна. 6 хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Дээрх хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн түвшинд 5 дүрэм, журам, Засгийн газрын түвшинд 14 журмыг баталгаажуулан хэрэгжүүлж байна. 10 зорилт бүгд 100 хувь буюу 5 гол үр гарсан. “Бүрэн хэрэгжсэн” байна.
2.	<i>Хоёрдугаарт.</i> Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:	12	12	12 зорилт бүгд 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн”
3.	<i>Гуравдугаарт,</i> Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:	10	10	10 зорилт бүгд 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн”
4.	Дөрөв. Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:	8	8	8 зорилт бүгд 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн”
5.	Тав. Батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг дэмжих ажиллагаан дахь Зэвсэгт хүчний оролцоог өргөжүүлэх хүрээнд	12	12	12 зорилт бүгд 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн”

	гүйцэтгэсэн арга хэмжээнүүд үнэлсэн байдал:			
6.	БҮГД	71	71	71 зорилт бүгд 100 хувь буюу “ Бүрэн хэрэгжсэн ” гэсэн үнэлгээ өгсөн

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж хүснэгтэд заасан 5 гол асуудлаар үнэлэхэд 71 зорилт бүгд 100 хувь буюу “**Бүрэн хэрэгжсэн**” гэсэн үнэлгээг хийлээ.

Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг”, батлан хамгаалах багц хуулиудад нийцүүлэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах Батлан хамгаалах салбарын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх зорилт, дэд зорилтоо тодорхойлж ажиллаж байна.

Дүгнэлт

“Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээ. Шифр: “Рейтинг” сэдэвт судалгаанд оролцогчдоос эрэгтэй 54%, эмэгтэй оролцогч 46%, насны хувьд 18-28 насныхан 20.9%, 29-39 насныхан 26.9%, 40-50 насныхан 28.2%, 51-61 насныхан 15.3%, 61-ээс дээш насныхан 8.7% хамрагдсан байгаа нь дундаж насныхан голчлон оролцсон бөгөөд судалгаа үнэн зөв авагдах боломжийг хангана гэж үзэж байна.

Батлан хамгаалахтай холбоотой хууль, эрх зүйн баримт бичгийн талаарх өөрийн мэдлэгээ хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултын хариултаас үзэхэд, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг 19% нь хангалттай, 44% нь дунд зэрэг, 37% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Дайчилгааны тухай хуульд 48% нь хангалттай, 19% нь дунд зэрэг, 32% нь хангалтгүй гэж үнэлсэн бол, Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хуульд 61% нь хангалттай, 13% нь дунд зэрэг, 32% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Харин Цэргийн албаны тухай хуульд 48% нь хангалттай, 19% нь дунд зэрэг, 30% нь хангалтгүй гэж үнэлсэн бол Зэвсэгт хүчний тухай хуульд 44% нь хангалттай, 21% нь дунд зэрэг, 35% нь хангалтгүй гэж үнэлжээ. Мөн Батлан хамгаалах тухай хуульд 41% нь хангалттай, 22% нь дунд зэрэг, 37% нь хангалтгүй гэж үнэлсэн бол, Батлан хамгаалах бодлогын үндэс

баримт бичгийн хувьд 50% нь хангалттай, 15% нь дунд зэрэг, 33% нь хангалтгүй гэж үнэлсэн байна.

Ажил эрхлэлттэй хамааралтай байдлаас харахад төрийн болон цэргийн байгууллагын албан хаагчдын “тодорхой хэмжээнд хамааралтай” гэсэн хариулт бусад салбарын ажилтнуудын хариулттай харьцуулахад харьцангуй илүү буюу Батлан хамгаалах бодлого-66%, Батлан хамгаалах тухай хууль-61%, Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль-60%, Дайчилгааны тухай хууль-61%, Орон нутгийн тухай хууль-60% хувь байгаа ажиглагдлаа.

Манай улс батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчиндээ хэр зэрэг төсөв, мөнгө зарцуулдаг бол гэсэн судалгааны хариултаас үзэхэд 4.5% нь хэт их, 25% нь хангалттай, 29% нь хэт бага, 42% нь мэдэхгүй гэж хариулснаас үзвэл Батлан хамгаалах салбарын талаарх иргэдийн сонирхол, оролцоо төдийлөн сайнгүй гэж дүгнэж болох бөгөөд энэхүү асуултыг Та Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, иргэн-цэргийн харилцаа өнөөдөр ямар түвшинд байна гэж бодож байна вэ? асуултад 6% нь маш сайн, 19% нь сайн, 39% нь дунд, 13% муу, 4% нь маш муу, 18% нь мэдэхгүй гэж хариулсан байдалтай харьцуулан үзвэл иргэн-цэргийн харилцааны гол асуудлуудын нэг болох Зэвсэгт хүчинд хэрэгжүүлэх иргэний хяналтыг цэргийн байгууллагыг байнга хардах, хянах гэсэн утгаар бус харин цэргийн болон иргэний удирдлага харилцан бие биенээ нөхсөн хамтын ажиллагаагаар үйл ажиллагаагаа явуулж, улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт түрэмгийллээс хамгаалах, байгалийн гамшиг, дотоодын дэг журам алдагдсан үед иргэний удирдлагад захирагдан орон нутгийн удирдлага, иргэний цагдаа, тагнуулын байгууллагыг дэмжин ажиллах, олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд хувь нэмрээ оруулах, энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох, байлдааны хүчин чадавхиа байнга нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд үндсэн зорилго, зорилтоо чиглүүлэх учиртай болж байна.

Монгол Улсын аюулгүй байдлын талаарх таны ойлголт ямар түвшинд байдаг вэ? гэсэн асуултад 16% нь сайн, 56% нь дунд, 23% нь муу, 6% нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд харин Таны бодлоор манай улсад доорх аюулгүй байдлын орчин хэрхэн хангагдсан гэж үзэж байна вэ? гэсэн асуултад хариулсан байдлаас үзэхэд, хүнсний аюулгүй байдал муу-47%, Эдийн засгийн аюулгүй байдал муу-46%, Мэдээллийн аюулгүй байдал муу-46%-тай байгаа нь анхаарал татаж байна.

Хувь хүний ашиг сонирхол зөвхөн нийтийн эрх ашигтай зохицсон, эв санааны нэгдэлд үндэслэсэн нийгмийн тогтолцооны нөхцөлд л бодитой

хангагддаг гэдгийг нэр хүндтэй олон судалгааны дүн батлан харуулдаг. Харин нийтийн эрх ашиг, хүсэл сонирхол, шаардлагыг хувь хүний эрх, эрх чөлөөтэй зохистой хослуулах хамгийн том арга хэрэгсэл бол иргэний нийгмийн идэвхтэй оролцоо гэж үзэж болно.

Хүн төрөлхтөн хүний эрхийг тогтоох бус хамгаалахад үйл ажиллагаа чиглүүлсэн, нийтлэг ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрсөн хуулиар зохицуулагдсан тогтолцоо бүхий төрийг бий болгохыг зорьсоор ирсэн билээ. Төрийн эрх мэдэл хуваарилах үйл явц нь тухайн цаг үе, нийгмийн болон хүмүүний аж төрөх ёсны онцлог, төрийн байгуулалт дахь уламжлал, шинжлэх ухаанч мэдээлэл, судалгааны байгууллагуудын түвшин зэрэг хүчин зүйлсээс хамааран хөгжсөөр өдгөө хүрчээ. Иймээс дээрх хууль тогтоомжийг боловсронгуй болгож бодлогын үйл явцыг ил тод, нээлттэй болгох, оролцоог хангах тодорхой механизм бүтцийг бий болгож, хэн хариуцах, хэзээ яаж хэрэгжүүлэх, хэрхэн санхүүжих зэргийг тодорхой болгох нь чухал байна. Хууль эрхзүйн мэдлэг, төрийн болон цэргийн алба хаагчдын хувьд ч хангалттай бус байна. Өөрөөр хэлбэл хэн нэгэн шийдвэр гаргагчийн хүсэл зоригоос хамааралгүйгээр аливаа асуудлыг албан механизм сувгуудаар хэлэлцэн санал зөвлөгөө авч байж явагдах жишиг стандартыг тогтоосноор өнөөгийн хүн бүрийн оролцоог хангаж чадна.

Хууль тогтоомж, шийдвэрийг тайлбарлан таниулах, сурталчлах, ойлгуулах ажил чухал ач холбогдолтой нь хэн бүхэнд ойлгомжтой. Энэ ажлыг хийхдээ орчин үеийн техник технологийн дэвшлийг яаж ашиглах вэ гэдэг талаар тодорхой шийдэлд хүрэх ёстой гэсэн дүгнэлтэд хүрч байна.

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж хүснэгтэд заасан 5 гол асуудлаар үнэлэхэд 71 зорилт бүгд 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” гэсэн үнэлгээг авч байгаа нь БХЯ өмнө тавигдсан зорилтыг хангаж байгаа нь харагдаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТАЛААР ОЛОН НИЙТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА

§2.1. Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, цэргийн алба хаагчдын өгсөн үнэлгээ

Монгол Улсын төрийн бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг бол аюулгүй байдлыг хангах явдал мөн. Төр, олон нийт, иргэдийн хамтын ажиллагаа, арга хэмжээний үр дүнд аюулгүй байдлыг хангах тухай “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тусгагдсан байдаг. Аюулгүй байдлыг хангахад батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний талаарх нийгмийн үнэлэмж чухал нөлөөтэй. Тиймээс олон нийтийн дунд Зэвсэгт хүчний үнэлэмжийн талаарх судалгааг тогтмол дамтамжтайгаар явуулж, түүндээ үндэслэсэн сургалт, сурталчилгааны ажлыг бодлого, төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж байх шаардлагатай. Үүний ач холбогдол нь иргэн-цэргийн харилцаа бэхжиж, Зэвсэгт хүчин ард түмний хооронд харилцан ашигтай түншлэлийн харилцаа хөгжихөд чухал нөлөө үзүүлнэ.¹⁷ Улс орны хэтийн зорилго, улстөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг гаднын түрэмгийллээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэн дотоод, гадаад аюулгүй байдлыг хангахад цэргийнхэн гол үүрэг гүйцэтгэдэг.

Ардчилсан нийгэмд шилжих шилжилтийн үед цэргийн байгууллагын гүйцэтгэх үүргийг шинээр тодорхойлох, иргэний улстөрийн эрх чөлөөг хүндэтгэсэн иргэний удирдлага бүхий цэргийн байгуулалтыг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгодог. Хэдийгээр төрийн тэргүүн Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх боловч энэ нь Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг бий болголоо гэсэн үг биш юм.

Төрийн тэргүүн цэргийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах боломж, цаг байхгүй учраас тэрээр Зэвсэгт хүчинг удирдах, хянах эрх мэдлийг гүйцэтгэх засаглал, иргэний Батлан хамгаалахын сайдад олгох тохиолдол нэлээд түгээмэл байдаг. Иргэний батлан хамгаалахын сайдын эрх үүргийг нэмэгдүүлэхийн тулд нэгд иргэний Батлан хамгаалахын сайдад цэргийн мэргэжлийн зөвлөгөө өгөх үүрэг бүхий цэргийн өндөр мэргэжлийн офицеруудыг багтаасан баг бүрдүүлэх, *хоёрт*, батлан хамгаалах яаманд ажиллаж байгаа цэргийн болон энгийн албан хаагчдын ажил, үүргийн хуваарийг нарийн гаргаж өгөх, *гуравт*, цэргийн удирдлагыг бүх шатанд тодорхой байдлаар зохион байгуулж, эрх мэдлийн давхардлыг арилгахыг чухалчилдаг.¹⁸

¹⁷БХЭШХ, “Зэвсэгт хүчин ба олон нийтийн үнэлэмж” шифр: “Үнэлэмж” сэдэвт судалгааны ажлын тайлан, УБ., 2011.

¹⁸Содбилэг.Б, “Үндэсний аюулгүй байдлыг хангах субъект-Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг боловсронгуй болгох нь” докторын диссертаци, УБ., 2017.

Иргэний нийгэмд Зэвсэгт хүчний улстөрийн удирдлагын чиг үүргийг тодорхойлж, улс орны бүтээн байгуулалт, дотоодын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд түүний оролцох хэм хэмжээг хуульчлан тогтоодог.

Зэвсэгт хүчин дотоодын үүрэг биелүүлэхэд ашиглах үед *нэгд*, цэргийн анги, салбарыг иргэний удирдлагад байнга захируулах, *хоёрт*, иргэний байгууллагыг дэмжих үүрэгтэйгээр дотоодын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцож байгааг цэргийн албан хаагчдад ойлгуулах, *гуравт*, хүний эрхийг зөрчсөн тохиолдол гарахаас урьдчилан сэргийлэх, *дөрөвт*, тухайн ажиллагааг дуусгах хугацааг тодорхой зааж өгөхөд онцгойлон анхаардаг байна.

Ардчилсан нийгэмд батлан хамгаалах асуудлаар мэргэшсэн иргэний болон цэргийн албан хаагчид бүхий Батлан хамгаалах яам нь иргэний батлан хамгаалахын сайдыг зөвлөгөө, мэдээллээр хангаж байдаг. Батлан хамгаалах яамны иргэний мэргэжилтнүүд нь стратеги, цэргийн хүч хэрэглэх дүрэм, зэвсэглэлийн төрөл, тоо ширхэг, Зэвсэгт хүчний чиг үүрэг, батлан хамгаалах төсвийн хэмжээ зэрэг олон асуудлаар цэргийн удирдлагатай зөвшилцөх, судалгаа хийх зэрэг асуудлыг эрхэлдэг байна. Батлан хамгаалах яам нь улстөрийн удирдлагыг цэргийн байгууллагатай холбох гүүр болж, улстөрийн шийдвэрийг батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх, цэргийн хэрэгцээг улстөрийн удирдлагад тайлбарлан ойлгуулах чухал үүргийг хэрэгжүүлдэг байна. Гүйцэтгэх засаглалын тэргүүн нь “гуравдагч” байгууллагын тусламжтайгаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний байгууллагуудад аудит, хяналт шинжилгээ хийлгэх туршлага барууны улсуудад нилээд элбэг тохиолддог¹⁹.

Батлан хамгаалах салбараас улстөр, эдийн засаг, нийгмийн амьдралд оролцож байгаа хүрээ нь янз бүр байна. Зэвсэгт хүчний оролцоо нь: *нэгдүгээрт*, улстөрийн тогтолцоо, *хоёрдугаарт*, Зэвсэгт хүчний удирдлага, бүтэц зохион байгуулалт, *гуравдугаарт*, аюулгүй байдалтай холбогдсон шийдвэр гаргах үйл явц, *дөрөвдүгээрт*, нийгэм, эдийн засгийн амьдрал, *тавдугаарт*, хууль сахиулах тогтолцоо зэрэг асуудалд голлон илэрнэ.

Одоо энэхүү судалгааны ажлын хүрээнд хийгдсэн Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, цэргийн алба хаагчдын өгсөн үнэлгээний үр дүнг 6 дугаар зургаар гаргаж харууллаа.

¹⁹Felipe Aguero, *Soldiers, Civilians, and Democracy: Post-Franco Spain in a Comparative Perspective*, Baltimore., John Hopkins University Press, 1995



2010 оны судалгаагаар Зэвсэгт хүчний нэр хүнд сайн гэсэн үнэлгээ 53.3%-ийг эзэлж байсан бол 2012 онд 21.3% хувь болж буурсан шалтгааныг өмнөх мөн үеийн олон нийтэд хүрсэн шиг тийм сурталчилгаа, мэдээллийн ажил явагдахгүй байгаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төр, сонгуультай холбогдол бүхий мэдээлэл түлхүү явагдаж

иргэдийн сэтгэл зүй энэ чиглэлд хандаж байсантай холбоотой байж болно²⁰ хэмээн дүгнэсэн байна. Харин 6 дугаар зургаас үзэхэд, энэхүү судалгааны үр дүнгээр сайн гэсэн үнэлгээ 45%-тай, муу гэсэн үнэлгээ 7% хувьтай харагдаж байна. “Сайн” эсвэл “муу” гэж хариулсан шалтгааныг тодруулан асуусан нээлттэй асуултын хэсэгт: Цэргийн алба хаагч албаа хаах хугацаандаа гэмтэх, бэртэх, амь насаа алдах тохиолдол гарч байна, ахлах албан тушаалтны хариуцлага муу, мэдээлэл муу, зэвсэг техник муутай гэсэн бол “Сайн” гэж хариулсан шалтгаанаа Олон улсад нэр хүнд сайтай, Энхийг сахиулах ажиллагаанд амжилттай сайн оролцдог, цэргийн алба хаагчдын ур чадвар сайн, олон улсад өндрөөр үнэлэгддэг зэргээр хариулсан байна.

Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх асуултуудыг хариултыг 5 дугаар хүснэгтээр үзүүлэв.

5 дугаар хүснэгт.

Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх асуултуудыг хариултын байдал

Асуулт / Үнэлгээ	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Мэдэхгүй
БХЯ-ны үйл ажиллагааг хэрхэн үнэлэх вэ?	5%	26%	37%	9%	3%	20%
ЗХЖШ-ын үйл ажиллагааг хэрхэн үнэлэх вэ?	6%	28%	33%	6%	2%	24%
ЦАХ-дын сахилга, хариуцлагын байдлыг хэрхэн үнэлэх вэ?	8%	27%	38%	10%	2%	14%
БХЯ, ЗХЖШ-аас зохион байгуулж буй иргэд олон нийтийн дунд бодлого ү.а-гаа сурталчлан таниулах ажлын чанар хүртээмжийг үнэлнэ үү.	5%	20%	36%	12%	4%	21%
Та МУ-ын Энхийг сахиулах үйл	31%	24%	27%	3%	2%	11%

²⁰БХЭШХ, “Зэвсэгт хүчин ба олон нийтийн үнэлэмж” шифр: “Үнэлэмж” сэдэвт судалгааны ажлын тайлан, УБ., 2011.

ажиллагааны хэрэгжилтийг үнэлнэ үү.						
Оюутан цэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх таны үнэлгээ.	18%	35%	27%	5%	2%	12%
Цэрэг татлагын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үнэлнэ үү?	11%	32%	35%	6%	3%	13%
Нийслэл, дүүргийн цэргийн штабын үйл ажиллагааг үнэлнэ үү?	5%	19%	35%	5%	5%	30%
БХ салбарын үйл ажиллагаа иргэдэд хэр нээлттэй гэж бодож байна вэ?	4%	14%	41%	13%	6%	28%
БХ салбарын төсвийн ил тод байдал, зарцуулалтын талаарх таны үнэлгээ?	4%	9%	34%	12%	6%	35%

Дээрх үр дүнгээс харахад Монгол Улсын Энхийг сахиулах үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээ хамгийн өндөр буюу “Маш сайн”-31%-тай байна. Мөн Оюутан цэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг “Сайн”-35%, Цэрэг татлагын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг “Сайн”-32%-тай үнэлсэн байгаа нь Зэвсэгт хүчний мэргэжлийн ур чадвар дээшилж, үүрэг гүйцэтгэх бэлэн байдал сайжирч, Энхийг сахиулах ажиллагаануудад амжилттай сайн оролцон, олон улсад нэр хүнд нь өсөхийн зэрэгцээ нэг хүнд ногдох энхийг сахиулагчдын тоогоороо манай улс Ази тивдээ тэргүүлж байгаа үр дүнтэй холбон тайлбарлаж болох юм. Мөн хүүхэд, залуучуудын эх оронч үзэл, үндэсний бахархлыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөрүүд батлагдан амжилттай хэрэгжиж байгаатай холбогдон цэрэг татлагын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт сайжрахын зэрэгцээ “Оюутан цэрэг” хөтөлбөр үр дүнтэй, үр өгөөжтэй байгаад хамрагдсан оюутнууд, тэдний эцэг эх сайшаалтай хандаж байгаа бөгөөд энэхүү судалгааны үр дүнгээр мөн харагдаж байна. Харин Батлан хамгаалах салбарын төсвийн ил тод байдал, зарцуулалтын талаарх үнэлгээнд “мэдэхгүй” гэсэн хариулт 35%-ийг эзэлж байгаа нь төсвийн ил тод байдлын талаар хуулийн заалтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг сайжруулах арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцон төсөвлөх, батлан хамгаалах төсвийг хэрхэн тогтвортой өсгөх, салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлын чанар, хүртээмжийг хэрхэн сайжруулах чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулах, бодит мэдээллээр хангах шаардлагатай байна гэж үзлээ.

Зэвсэгт хүчний талаар иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалж:

Зэвсэгт хүчний бодлого, үйл ажиллагаа, ур чадвар, чадавх, цэргийн анги байгууллагын орчин нөхцөл, цэргийн албаны онцлог, тайван болон байлдааны цагт гүйцэтгэх үүрэг, боломж, иргэн-цэргийн харилцаа болон хамтын ажиллагаа, зэвсэг техникийн шинэчлэлийн асуудал, гадаад харилцаа, энхийг дэмжих ажиллагаа зэрэг мэдээллийг үнэн бодитоор, мэдээллийн түгээмэл хэрэгслээр түгээх нь ач холбогдолтой.

Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбоотой дээрх мэдээ, мэдээлэл нь олон нийтэд эерэг хандлага бий болгох эсэх нь БХЯ, ЗХЖШ-аас нийгэмд хүргэж байгаа мэдээллийн чанар, үнэн бодит байдал, арга техникээс (кино, баримтат нэвтрүүлэг, цэнгээнт нэвтрүүлэг болон шоу гэх мэт) ихээхэн хамаарна.²¹

Мөн нэг талыг барьсан мэдээллийн үр өгөөж муу байдаг. Тиймээс олон нийтэд Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар санал солилцох боломжийг олгож байх шаардлагатай. Олон нийтийн оролцоо нь аливаа салбарын үйл ажиллагааг удаан хугацаагаар тогтвортой байлгахад чухал үүрэгтэй байдаг. Хоёр урсгалын харилцаа холбоо нь дараах шалтгааны улмаас үр дүнгээ өгч болох юм. Үүнд:

- Олон нийтийн оролцоо, байнгын хяналтыг бий болгоно;
- Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд итгэх итгэл төрүүлнэ;
- Энэ нь хууль тогтоомж, төр засгийн бодлогыг хууль ёсны, олон нийтийн дэмжлэг авахад дөхөмтэй болгож ардчиллыг тогтворжуулна.

Тиймээс судалгааны явцад Зэвсэгт хүчний талаар иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж байгаа эх сурвалжийг тодорхойлохоор Та Зэвсэгт хүчинтэй холбогдолтой мэдээ, мэдээллийг ихэвчлэн ямар эх сурвалжаас авдаг вэ? гэсэн асуултад хариулсан байдлыг өмнөх оны судалгааны дүнгүүдтэй харьцуулан 6 дугаар хүснэгтээр харуулав.

6 дугаар хүснэгт.

Зэвсэгт хүчинтэй холбогдолтой мэдээ, мэдээллийг ихэвчлэн ямар эх сурвалжаас авдаг вэ? гэсэн асуултад хариулсан байдлыг өмнөх оны судалгааны дүнгүүдтэй харьцуусан хүснэгт

№	Хариулт	1993	1997	1999	2000	2002	2003	2006	2010	2012	2019
1.	Телевиз	41%	45.5%	46.4%	37.1%	55.8%	52.8%	63%	87.3%	45.7%	71.1%
2.	Радио	18.8%	25.8%	26%	16%	10%	16.1%	6.8%	0.7%	33%	5.5%
3.	Хэвлэл	36%	40.5%	49.1	41.4	20.2%	35.3%	20.4%	8.3%	3.7%	12.5%
4.	Интернэт	4.6%	6%	6.8%	6.1%	3.6%	5.9%	10%	25%	17.7%	42.2%

Телевизээс авдаг гэсэн хариулт энэ зүйл харьцангуй өсөлттэй харагдаж байгаа бол радиогоос авдаг гэсэн хариулт маш бууралттай байна. Харин интернэтээр гэсэн сонголтод нийгмийн сүлжээний олон төрлийн вэб сайтууд, онлайн хэвлэлүүд багтаж байгаа учраас өсөлттэй гарсан дүн ажиглагдаж байна.

²¹БХЭШХ, “Зэвсэгт хүчин ба олон нийтийн үнэлэмж” шифр: “Үнэлэмж” сэдэвт судалгааны ажлын тайлан, УБ., 2011.

Та манай улсын ЗХ-ний талаарх ямар мэдээллийг ихэвчлэн сонирхдог вэ? (гол гэсэн 2-4 хариултыг сонгоно уу) гэсэн асуултыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулан хронологи гаргаж 7 дугаар хүснэгтээр үзлээ.

7 дугаар хүснэгт.

Та манай улсын ЗХ-ний талаарх ямар мэдээллийг ихэвчлэн сонирхдог вэ? (гол гэсэн 2-4 хариултыг сонгоно уу) гэсэн асуултыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулан хронологи гаргаж үзүүлсэн хүснэгт

№	Хариулт / Он	1999	2000	2002	2003	2006	2010	2012	2019
1.	Зэвсэгт хүчний гадаадад явуулж буй үйл ажиллагааг	-	-	-	-	59.4%	56.3%	53.8%	50.3%
2.	Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын ур чадварыг	-	-	-	-	35.4%	35%	34.9%	45.7%
3.	Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын талаар	34.1%	31.2%	18.5%	34.9%	28.8%	22%	19.6%	32%
4.	Офицер, ахлагч нарын талаар	11.7%	18.7%	6.1%	15.2%	14.3%	10.3%	18.5%	26%
5.	Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын сахилга, хариуцлага	21.1%	34.8%	17.3%	33.9%	28.6%	25%	17.8%	23%
6.	Зэвсэгт хүчний байдааны техник хэрэгслийн шинэчлэл, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх боломж	24.9%	25.5%	7.8%	18.6%	46%	39.7%	36.7%	26%
7.	Цэргийн шинэчлэл салбарын үйл ажиллагааны талаар	32.5%	39.5%	16.6%	28%	28%	20.7%	29.5%	23%
8.	Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллын талаар	-	-	-	-	38.9%	21.7%	27.6%	30%
9.	Гадаад харилцааны талаар	-	-	8.6%	15.6%	21.3%	35.7%	29.5%	-

Эдгээр асуудлуудын дотроос Зэвсэгт хүчний гадаадад явуулж буй үйл ажиллагаа, энхийг сахиулах олон улсын ажиллагааны тухай болон олон улсын ажиллагаанд нэр төртэй, амжилттай үүрэг гүйцэтгэж байгаа Монголын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын ур чадварын тухай мэдээллийг хамгийн ихээр сонирхдог хэмээн хариулжээ. Энэ нь сүүлийн үед манай Зэвсэгт хүчний гадаадад явуулж буй ажиллагаа, бодлогын үр дүн гэдэг нь тодорхой. Мөн иргэд Зэвсэгт хүчний талаар хамгийн их сонирхож байгаа сэдэв бол Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын талаар, Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудал байна. Мөн Зэвсэгт хүчний зэвсэг, техник хэрэгслийн шинэчлэл, орчин үеийн зэвсэг, техник хэрэгслийн хангалт, зэвсэг, техник хэрэгслийн үүрэг гүйцэтгэх боломжийн асуудал байна.

Энэ оны судалгааны дүнгээр эрэмбэлэн харвал ихэвчлэн сонирхдог мэдээлэл нь Зэвсэгт хүчний гадаадад явуулж буй үйл ажиллагаа буюу энхийг дэмжих ажиллагаа, цэргийн алба хаагчдын ур чадварын тухай, хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын тухай, цэргийн алба хаагчдын нийгмийн хамгаалал, Зэвсэгт хүчний байдааны техник хэрэгслийн шинэчлэл, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх боломжийн талаар гэсэн дараалалтай байна. Тиймээс цаашид Зэвсэгт хүчний бодлого үйл ажиллагааг түлхүү сурталчилан таниулж, илүү нээлттэй ил тод, олон нийтэд ойр, байлгах шаардлагатай. Цаашид иргэд доорх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгожээ. Үүнд:

- Зэвсэг техникээ сайжруулах;
- Батлан хамгаалах салбарын төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Боловсон хүчнээ хангалттай сайн бэлтгэх;
- Салбарын үйл ажиллагааг нээлттэй болгох;
- Залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх;
- Гадаадад явуулж буй үйл ажиллагаагаа өргөжүүлэх.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдан хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа зарим аймагт явагдсан тухайлбал, Завхан аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд 2018 оны 9-р сарын 5-аас 20-ны өдрүүдэд Бид Чингисийн үр сад, “Зөв тэмүүлэл-Эх оронч манлайлал” сургалтыг зохион байгуулсан Ерөнхий боловсролын сургуулийн хэмжээнд “Зөв тэмүүлэл-Эх оронч манлайлал” хөтөлбөр явагдаж эхэлсэн зэргийг сайнаар үнэлсэн байна.

Олон нийтийн санал бодлын судалгаа, өрнөдийн орнуудын зарим туршлага, нийгмийн сэтгэл зүйн хандлагуудаас дүгнэж үзэхэд тусгайлан зориудаар бэлтгэсэн мэдээ, мэдээллийг олон нийтийн бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тасралтгүй, давтамжтайгаар хүргэж чадвал Зэвсэгт хүчний талаар эерэг үнэлэмжийг бүрдүүлэх чиглэлд нийгмийн сэтгэл зүйг жолоодох боломжтой гэж дүгнэж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар иргэд, олон нийт тодорхой мэдлэг, мэдээлэлтэй болж байгаа бөгөөд түүний хэрээр салбарын гадаад харилцаа, энхийг дэмжих үйл ажиллагаа, зэвсэглэл, техник хэрэгсэл, нийгмийн хамгаалал, цэргийн алба хаагчдын ур чадварын тухай илүү ихээр сонирхох болжээ. Цаашид үйл ажиллагаандаа анхаарууштай цөөнгүй зүйл байгаа бөгөөд иргэд энэ талаар: Зэвсэгт хүчнийхээ

бүтэц зохион байгуулалтыг оновчтойгоор сайжруулах, цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, төсөв хөрөнгө зарцуулж буй байдлыг ил тод болгох, анги салбарын ажил үйлсийг жигд сайжруулах гэх мэт олон асуудлыг дурдсан байна.

§2.2. Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог хангах боломж

Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог хангах асуудалд иргэн-цэргийн харилцаа, иргэний нийгмийн оролцоо зэрэг асуудлуудыг авч үзэж болно. Учир нь Зэвсэгт хүчний үүрэг, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөлөлтэй холбоотойгоор иргэн-цэргийн харилцааны судалгааны зарим чиглэл тодорхойлогддог. Тухайлбал: Зэвсэгт хүчин нь зарим тохиолдолд улс орны бүтээн байгуулах үйл ажиллагаанд оролцдог. Энэ утгаараа цэргийн алба нь “техникийн болон захиргааны арга чадварыг иргэдэд эзэмшүүлж, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах сургууль мөн” гэсэн хандлага байдаг. Зэвсэгт хүчнийг батлан хамгаалах аж үйлдвэр, худалдааны үйлдвэрлэл явуулах, радио, телевизийн сүлжээг зохион байгуулах, иргэний агаарын тээврийг удирдах, хөдөө аж ахуйг зохион байгуулах зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа явуулах, боловсрол, эрүүл мэнд, иргэний хамгаалалтын ажилд ашигладаг нийтлэг жишиг байна.

Монгол Улсын хувьд “Батлан хамгаалах бодлогын үндэс”(2015) баримт бичиг: Нийт 4 бүлэг, 32 зүйлтэй энэхүү бодлогын баримт бичиг батлагдсанаар батлан хамгаалах салбарын эрх зүйн тулгуур үндэс шинэчлэгдэж, үүнийг дагалдан батлан хамгаалахын багц хуулиудыг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах үндэс тавигдаж байгаа юм. Тус баримт бичигт Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын асуудлыг өргөн агуулгаар авч үзсэн төдийгүй Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих субъектуудыг тодорхой болгож эрх үүргийг нь зааж өгсөн нь Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих үндэслэл, батлан хамгаалах салбарын шинэчлэлд түлхэц өгсөн үйл явдал болсон. Тухайлбал: 1.3-д Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Засгийн газар хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хурал хяналт тавина. 2.7-д Батлан хамгаалахын удирдлагыг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан

хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ. 2.8-д Батлан хамгаалахын иргэний болон цэргийн удирдлагын харилцааг хуулиар зохицуулна. 2.9-д Батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ хийх үндсэн үүргийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ. 6.3-д Зэвсэгт хүчний ардчилсан удирдлагыг бэхжүүлж, зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг төгөлдөржүүлнэ гэж тус тус заажээ²².

Харин орчин үед Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь дэлхийн аль ч улс гүрний тухайд түүний нийгэм, улстөрийн тогтолцооноос хамааран янз бүрийн агуулга, хэлбэрээр хэрэгжиж байдаг бөгөөд энэ ойлголт, үзэл баримтлал өнөөг хүртэл бүрэн гүйцэд судлагдаагүй, төлөвшөөгүй гэж судлаачид үзэж байна.²³

Ардчилсан иргэний хяналт гэдэг нь ардчилсан нийгэмд Зэвсэгт хүчин нь улс орны аюулгүй байдлыг хангах үүргээ хэрхэн биелүүлж байгааг жирийн татвар төлөгчөөс улс орны тэргүүн хүртэл хянах боломжийг олгоход чиглэдэг бол улстөрийн хяналт нь Зэвсэгт хүчнийг тухайн нийгмийг удирдаж байгаа улстөрийн хүчний баримталж буй үзэл сурталд үнэнч байлгахад чиглэнэ.

Тухайн нийгмийн аюулгүй байдлыг хангах эрхэм үүрэг хүлээсэн Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэх нь *нэгдүгээрт*, улсын төсвийн зарцуулалтыг хянах, *хоёрдугаарт*, цэргийн хүчийг хүн амын эсрэг ашиглах, *гуравдугаарт*, улс төрийн аливаа хүчин цэргийн байгууллагыг улстөрийн зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой. Өөрөөр хэлбэл иргэний хяналт нь нийгэм дэх хүчний байгууллагууд, тухайлбал Зэвсэгт хүчнийг улстөрийн удирдлагаар хангах, тэднийг нийт ард түмнээр /нийгмээр/ хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бий болгоход чиглэгдэнэ.

АНУ болон өрнөдийн зарим судлаачид Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын агуулга, механизмыг судалж, тодорхой үзэл баримтлал дэвшүүлсэн байна.

Тэдний үзэж байгаагаар Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх субъектийг төр, иргэд, байгууллагууд (татвар төлөгчид), иргэний нийгэм гэсэн 3 үндсэн хэсэгт хуваасан байна. Төр-Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалахын сайд, Батлан хамгаалах яам болон бусад яамд; иргэд,

²²Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг.

²³Jason Dempsey, Jay Parker, and Thomas Sherlock, «Introduction to Civil-Military Symposium: Public Administration and Management», Public Administration and Management 10, no. 2 (2005)

байгууллага-татвар төлөгч иргэд, тэдний үүсгэл санаачилгаар байгуулагдсан төрийн бус олон нийтийн байгууллага, холбоо, нийгэмлэг багтдаг.

Иргэний хяналтын эдгээр субъектүүд өөр хоорондоо нягт харилцан уялдаатайгаар хэрэгждэг байна. Тухайлбал: ардчилал хөгжсөн улс орнуудад Батлан хамгаалах яамыг иргэний улстөрийн зүтгэлтэн толгойлж ажиллах нь Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэх зарчмын нэг чухал хүчин зүйл болдог байна. Ийм тохиолдолд Батлан хамгаалахын сайд улстөрийн зүтгэлтэн-төрийн сайд, өөрөөр хэлбэл, төр засгийн зүгээс цэрэгт тавих хяналтыг хэрэгжүүлэгч субъект учраас “иргэн-төр, засаг-цэрэг” гэсэн дэд тогтолцоо харагдаж байна. Ардчилсан нийгэмд иргэд, татвар төлөгч нар нь төрийн эрх барих дээд байгууллага-парламент болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг сонгох сонгуульд идэвхтэй оролцож тэнд өөрсдийн итгэмжлэгдсэн төлөөллийг бий болгосноор төсвийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, улмаар төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөл бүрэлддэг байна. Зэвсэгт хүчин нь улсын төсөв дээр “суудаг” томоохон салбарын нэг болохоор түүнд тавих иргэний хяналт ч ийм логикоор хэрэгжих бөгөөд “иргэн-парламент-цэрэг” гэсэн субъектүүдийн холбоо үүсч байдаг. Иргэний ардчилсан нийгэмд иргэд нь өөрсдийн аль ч /чөлөөт/ байгууллагуудаар дамжуулан төрийн хэрэгт оролцох боломжтой байдаг болохоор “иргэний нийгэм” гэдэг ойлголт нь дээрх дэд тогтолцоонуудыг өөртөө агуулж байна.²⁴

Өнөө үед аливаа нийгэм нь гадны зэвсэгт түрэмгийлэл, алан хядах болон хорлон сүйтгэх үйл ажиллагаа, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос авран хамгаалах зорилго бүхий цэргийн байгууллага, Зэвсэгт хүчинтэй байх шаардлага улам бүр өсч байна.

Энэ нь нийгмийн үнэт зүйлсэд хамгийн бага хохирол учруулах замаар цэргийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангахуйц иргэний хяналтын тогтолцоог бий болгоход оршиж байна. Иргэний хяналт нь тухайн нийгмийн хууль ёсны улстөрийн засаглал болон үнэт зүйлсийн тогтолцоонд хүчний байгууллагуудын тогтвортой байдлыг хангах гол зорилгыг агуулдаг байна. Энэ утгаараа Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь иргэдийн эрх, эрх чөлөөнд хэзээ ч аюул занал учруулахгүй гэсэн баталгаа болж өгдөг байна. Өрнөдийн ихэнх улс оронд Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавихдаа дараах зарчмуудыг удирдлага болгодог байна. Зарим үндсэн зарчмуудыг авч үзье.

²⁴Содбилэг.Б, “Үндэсний аюулгүй байдлыг хангах субъект-Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг боловсронгуй болгох нь” докторын диссертаци, УБ., 2017.

1. Төр, Зэвсэгт хүчний хоорондын харилцааны үндсэн шинж чанаруудыг Үндсэн хуулиар тогтоосон зарчимд нийцүүлэн тодорхойлж, тэдгээрийн хууль, эрх зүйн хэм хэмжээг тогтоож өгөх; (Энэ зарчим нь хуулийг дээдэлж, Зэвсэгт хүчний асуудлаар улстөрийн засаглалын зарим талуудын хооронд болон улстөр, цэргийн дээд эрхтэнүүдийн хооронд аливаа маргаан гарах нөхцөлийг хааж өгдөг байна.)

2. Батлан хамгаалах болон аюулгүй байдлын холбогдолтой хуулиудыг хэлэлцэх, Үндэсний батлан хамгаалах стратегийг тодорхойлох, батлан хамгаалах бодлогын чиглэлээр шийдвэр гаргах, төсөв батлах ба түүний зарцуулалтад хяналт тавих зэрэгт парламент идэвхтэй оролцох;

3. Батлан хамгаалах яам нь иргэний байгууллага байж Зэвсэгт хүчнийг удирдах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

4. Зэвсэгт хүчин нь өндөр боловсрол, мэдлэг чадвартай боловсон хүчнээр хангагдсан, ард түмнээр хүлээн зөвшөөрдсөн байх; (Ингэснээр Зэвсэгт хүчин нь улс төрийн талаар хараат бус байдлаа хадгалан иргэний хяналт жинхэнэ утгаараа хэрэгждэг)

5. Батлан хамгаалах яам нь захиргааны болон мэргэжлийн удирдлагын тэнцвэрийг хангах, батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар мэргэжсэн энгийн шинжээч, мэргэжилтэн, төрийн захиргааны албан хаагчдыг бэлтгэхэд барууны өндөр хөгжилтэй орнууд, тухайлбал, АНУ, Франц, Япон гол анхаарлаа хандуулж, цэргийн удирдлагын сургалт, дамжаанд батлан хамгаалах салбартай холбоотой ажил эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагын хүмүүсийг хамруулдаг уламжлал тогтоод байна. Үүнд: АНУ-ын Үндэсний Батлан хамгаалахын их сургууль, Францын Батлан хамгаалах судлалын хүрээлэн, мөн Япон Улсын Үндэсний батлан хамгаалах асуудал судлалын хүрээлэн зэрэг багтана. Энэ нь нэг талаар иргэн, цэргийн байгууллагуудын харилцан ажиллах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн алхам боловч, нөгөөтэйгүүр Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг бэхжүүлэхэд энэ салбарын талаар мэргэжсэн хүмүүсийг бэлтгэх зорилготой.

Одоо Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог хангахадөөр ямар боломж байж болохыг тодруулах зорилгоор асуулгын судалгааны үр дүнд хамаарлыг судлах аргачлалаар шинжилгээ хийж 8 дугаар хүснэгтээр үзүүлэв.

8 дугаар хүснэгт.

Хамаарлын шинжилгээ

Correlations		БХЯ-ны үйл ажиллагаа	ЗХЖШ-ын үйл ажиллагаа	ЭСА-ны хэрэгжилт	Багц хуулиудын хэрэгжилт	Иргэн-цэргийн харилцаа	Цэрэг татлагын үйл ажиллагаа	ЗХ-ний талаарх мэдээлэл	БХ салбарын төсвийн илтөд байдал
Аюулгүй байдлын тухай ойлголт	Pearson Correlation	.246**	.169**	.156**	.558**	.342**	.355**	.406**	.399**
	Sig. (2-tailed)	0.000	0.001	0.003	0.000	0.000	0.000	0.000	0.000
	N	358	358	353	356	357	354	354	354
Аюулгүй байдлын орчин	Pearson Correlation	-.369**	.318**	-.243**	-.225**	-.313**	.318**	.195**	.175**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.004	0.000	0.000	0.000	0.000	0.001
	N	353	353	354	355	354	353	353	348
ЗХ-ний талаарх мэдээ, мэдээллийн эх сурвалж	Pearson Correlation	-.116*	-.124*	-0.061	.175**	-.129*	-0.054	-0.081	-0.008
	Sig. (2-tailed)	0.031	0.020	0.254	0.001	0.016	0.312	0.134	0.880
	N	349	348	346	348	348	348	347	341
МУ-ын ЗХ-ний нэр хүнд, хүчин чадал	Pearson Correlation	.166**	.421**	.269**	.380**	.402**	.456**	.074**	.061**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.002	0.000
	N	356	352	358	355	356	355	355	356
МУ-ын ЗХ-ний АБ-д гүйцэтгэх үүрэг	Pearson Correlation	.679**	.509**	-.240**	.389**	.355**	.486**	.432**	.021**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000
	N	354	352	353	353	354	353	348	349
БХ салбарын төсөв, мөнгөний зарцуулалт	Pearson Correlation	-.200**	-.151**	.288**	-.190**	.197**	0.030	.142**	.182**
	Sig. (2-tailed)	0.000	0.004	0.000	0.000	0.000	0.583	0.009	0.001
	N	351	353	351	345	341	341	334	334
ЦАХ-дын ур чадвар, үүрэг хариуцлага	Pearson Correlation	.449**	.427**	.466**	.313**	.129*	0.081	.318**	.195**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.015	0.134	0.000	0.000
	N	357	356	354	349	349	341	353	353

Хамаарлын шинжилгээний үр дүнгээс харахад БХЯ-ны үйл ажиллагаа, ЗХЖШ-ын үйл ажиллагаа нь Монгол Улсын Зэвсэгт хүчний Аюулгүй байдалд гүйцэтгэх үүрэг, ЦАХ-дын чадвар, үүрэг хариуцлага, Аюулгүй байдлын орчинтой эерэг хүчтэй хамааралтай (Sig .000), Иргэн, цэргийн харилцаа, Цэрэг татлагын үйл ажиллагаа нь Аюулгүй байдлын тухай ойлголт, Аюулгүй байдлын орчин, МУ-ын ЗХ-ний нэр хүнд, хүчин чадалтай эерэг хамааралтай (Sig .000) байна. ЭСА-ны хэрэгжилт нь ЦАХ-дын ур чадвар, үүрэг хариуцлагатай хүчтэй эерэг, МУ-ын ЗХ-ний нэр хүнд, хүчин чадалтай эерэг харин Аюулгүй байдлын орчинтой урвуу хамааралтай (Sig .004) байна. Батлан хамгаалах багц хуулиудын хэрэгжилт нь

Аюулгүй байдлын тухай ойлголт, МУ-ын ЗХ-ний аюулгүй байдалд гүйцэтгэх үүрэг, МУ-ын ЗХ-ний нэр хүнд, хүчин чадал, ЦАХ-дын ур чадвар, үүрэг хариуцлагатай эерэг хүчтэй хамааралтай (Sig .000) байгаа бол Батлан хамгаалах салбарын төсвийн ил тод байдал нь Аюулгүй байдлын тухай ойлголттой хүчтэй эерэг харин Батлан хамгаалах салбарын төсөв, мөнгөний зарцуулалттай эерэг сул (Sig. 000) хамааралтай, ЗХ-ний талаарх мэдээ, мэдээллийн эх сурвалжтай хамааралгүй (Sig .880) байна.

Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлж, Зэвсэгт хүчний шинэчлэлийн асуудлыг сайжруулахын тулд цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тодруулсан нээлттэй асуултын үр дүнгээс харахад алба хаагчдын эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, нийгмийн асуудалд анхаарах, нарийн мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, зэвсэг техникийн шинэчлэл хийх, батлан хамгаалах бодлого, төлөвлөгөөг олон жилээр хийж, биелэлтийн тасралтгүй ажиллагааг хангах, гадаад улс орнуудтай харилцаагаа өргөжүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах, олон нийтэд нээлттэй ил тод мэдээллийг хүргэдэг байх зэрэг хариултауд давуу хувийг эзэлсэн байна.

Дүгнэлт

Судалгааны дүнгээс үзэхэд олон нийт Зэвсэгт хүчний холбогдолтой мэдээллийг сүүлийн хэдэн жил гол төлөв телевиз, интернэтээс авах болсон нь олон нийтийн дунд тархах мэдээллийн хүрээ тэлж байгаа нь ажиглагдаж байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд нь төр, засгийн байгууллагууд албан ёсоор хүлээж авахуйц бодитой мэдээллийг олны хүртээл болгоход онцгой анхаардаг. Гэхдээ Зэвсэгт хүчний үйл ажиллагааг нээлттэй болгох асуудал нь ардчилсан улс орнуудад ч гэсэн маргаантай асуудлын нэг юм. Зэвсэгт хүчин нээлттэй байх, нууцыг хадгалах эрмэлзэл хоёрын хоорондын зөрчил зарчмын хувьд хэзээ ч шийдэгддэггүй байна. Хэдий тийм боловч ардчилсан улс орнуудын нийтлэг жишгээр авч үзвэл нээлттэй байдлыг аль болохоор нэмэгдүүлэх чиглэл хандлагыг тууштай барьж байна.

МУ-ын ЗХ-ний нэр хүнд ямар түвшинд байгаа талаар судалгаа явуулахад судалгаанд оролцогчдын 45% сайн, 40% дунд, 8% мэдэхгүй, 7% муу гэсэн үнэлгээний хувьтай харагдаж байгаа нь төдийлөн өндөр түвшинд байхгүй байна.

Мөн Монгол Улсын Энхийг сахиулах үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээ хамгийн өндөр буюу “Маш сайн”-31%-тай байгаа бол Оюутан цэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг “Сайн”-35%, Цэрэг татлагын үйл ажиллагааны зохион

байгуулалт, хэрэгжилтийг “Сайн”-32%-тай үнэлсэн байгаа нь Зэвсэгт хүчний мэргэжлийн ур чадвар дээшилж, үүрэг гүйцэтгэх бэлэн байдал сайжирч, Энхийг сахиулах ажиллагаануудад амжилттай сайн оролцон, олон улсад нэр хүнд нь өсөхийн зэрэгцээ нэг хүнд ногдох энхийг сахиулагчдын тоогоороо манай улс Ази тивдээ тэргүүлж байгаа үр дүнтэй холбон тайлбарлаж болох юм.

Батлан хамгаалах салбар иргэд хоорондын харилцан ойлголцлыг шинэ шатанд гаргах үүднээс Дуулга теле студийн нэвтрүүлгийн бодлогыг зөвхөн салбарын мэдээ, мэдээлэл хүргэдэг хандлагаас залуучууд руу чиглүүлсэн хэсэгтэй болгох, эфирийн цагийг уртасгах, илүү шинэлэг, нээлттэй уур амьсгал оруулах, салбарын хууль, эрхзүйн баримт бичгүүдийн хэлэлцүүлэг, тайлбарыг хийдэг байх шаардлага байгааг урд онуудын болон энэ судалгааны дүгнэлтүүд харуулж байна.

Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь субъектын хувьд мөн тогтолцоо юм. Субъектив иргэний хяналт нь Үндсэн хууль, Засаглалын байгууллага, нийгмийн янз бүрийн давхаргын зүгээс цэргийн үйл ажиллагааны бүхий л хүрээнд хяналт тавьж цэргийнхний эрх мэдлийг аль болохоор хязгаарлахад чиглэгдэж байхад объектив иргэний хяналт гэдэг нь цэргийнхний мэргэжлийн ур чадварыг дээд зэргээр ахиулахад чиглэгдэж байдгаараа онцлогтой бөгөөд энэ хоёр нь эсрэг тэсрэг бус харин бие биеэ харилцан нөхцөлдүүлж байдаг байна.

Дээрх байдлаас Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх үндсийг тодорхойлбол:

- төрийн батлан хамгаалах бодлогыг боловсруулж, түүний үндсэн чиглэлүүдийг тодорхойлох;
- батлан хамгаалах салбарын байгууллагуудыг удирдлагаар хангах;
- Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг тогтоож өгөх; цэргийн гадаад харилцааг бэхжүүлэх;
- санхүү, зэвсэглэл техник, материал хэрэгслийн хангалтыг зохион байгуулах, боловсон хүчин бэлтгэх, цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах зэрэг асуудлуудыг оновчтой шийдвэрлэх, эцсийн дүндээ цэргийн оператив, байлдааны бэлэн байдал, сургалт бэлтгэлийг чанаржуулж, чадварлаг, мэргэжлийн Зэвсэгт хүчинтэй байх зорилт амжилттай биелэгдэнэ гэж үзэв.

ТӨГСГӨЛ

“Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээ. Шифр: “Рейтинг” сэдвээр судалгааны ажлыг нэгдүгээр бүлэг “Батлан хамгаалах

бодлого, үйл ажиллагааны талаарх иргэдийн оролцооны агуулга, түүний хэлбэрийг хангах үндэслэл"-ийг Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хэлбэр, Батлан хамгаалах эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх шинжилгээг олон нийтийн санал бодлын шинжилгээ, БХЯ-ны бодлого, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээ гэсэн хоёр дэд бүлэгтэй, Хоёрдугаар бүлэг "Монгол Улсын Зэвсэгт хүчний талаар олон нийтийн үнэлгээний судалгаа"-г Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, цэргийн алба хаагчдын өгсөн үнэлгээ, Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог хангах боломж гэсэн хоёр дэд бүлэгтэйгээр тус тус гүйцэтгэлээ.

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг *нэгд*, Батлан хамгаалахын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд, *хоёрт*, Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд, *гуравт*, Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд, *дөрөвт*, Үлсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх хүрээнд, *тавд*. Батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг дэмжих ажиллагаан дахь Зэвсэгт хүчний оролцоог өргөжүүлэх хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнүүд гэсэн байдлаар үнэлгээ хийлээ.

БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримталж хүснэгтэд заасан 5 гол асуудлаар үнэлэхэд 71 зорилт бүгд 100 хувь буюу "Бүрэн хэрэгжсэн" гэсэн үнэлгээг авч байгаа нь БХЯ өмнө тавигдсан зорилтыг бүрэн хангаж байгааг харуулж байна.

"Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээ. Шифр: "Рейтинг" сэдэвт судалгаанд оролцогчдын 54%- эрэгтэй, 46%- эмэгтэй, насны хувьд 18-28 насныхан 20.9%, 29-39 насныхан 26.9%, 40-50 насныхан 28.2%, 51-61 насныхан 15.3%, 61-ээс дээш насныхан 8.7% хамрагдсан байгаа нь дундаж насныхан голчлон оролцсон бөгөөд судалгаа үнэн зөв авагдах боломжийг хангасан гэж үзэж байна.

Батлан хамгаалахтай холбоотой хууль, эрх зүйн баримт бичгийн талаарх мэдлэгээ хэрхэн үнэлж байгаа талаарх асуултын хариултаас үзэхэд, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг 19% нь хангалттай, 44% нь дунд зэрэг, 37% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Дайчилгааны тухай хуульд 48% нь хангалттай,

19% нь дунд зэрэг, 32% нь хангалтгүй гэж үнэлсэн бол, Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хуульд 61% нь хангалттай, 13% нь дунд зэрэг, 32% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Харин Цэргийн албаны тухай хуульд 48% нь хангалттай, 19% нь дунд зэрэг, 30% нь хангалтгүй гэж үнэлсэн бол Зэвсэгт хүчний тухай хуульд 44% нь хангалттай, 21% нь дунд зэрэг, 35% нь хангалтгүй гэж үнэлжээ. Мөн Батлан хамгаалах тухай хуульд 41% нь хангалттай, 22% нь дунд зэрэг, 37% нь хангалтгүй гэж үнэлсэн бол, Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн хувьд 50% нь хангалттай, 15% нь дунд зэрэг, 33% нь хангалтгүй гэж үнэлсэн нь иргэдийн мэдлэг төдийлэн өндөр биш байна.

Ажил эрхлэлттэй хамааралтай байдлаас харахад төрийн болон цэргийн байгууллагын албан хаагчдын “тодорхой хэмжээнд хамааралтай” гэсэн хариулт бусад салбарын ажилтнуудын хариулттай харьцуулахад харьцангуй илүү буюу Батлан хамгаалах бодлого-66%, Батлан хамгаалах тухай хууль-61%, Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль-60%, Дайчилгааны тухай хууль-61%, Орон нутгийн тухай хууль-60% хувь байгаа ажиглагдсан нь боломжийн байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Манай улс батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчиндээ хэр зэрэг төсөв, мөнгө зарцуулдаг бол гэсэн судалгааны хариултаас үзэхэд 4.5% нь хэт их, 25% нь хангалттай, 29% нь хэт бага, 42% нь мэдэхгүй гэж хариулснаас үзвэл Батлан хамгаалах салбарын талаарх иргэдийн сонирхол, оролцоо төдийлөн сайнгүй гэж дүгнэж болох бөгөөд энэхүү асуултыг Та Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, иргэн-цэргийн харилцаа өнөөдөр ямар түвшинд байна гэж бодож байна вэ? асуултад 6% нь маш сайн, 19% нь сайн, 39% нь дунд, 13% муу, 4% нь маш муу, 18% нь мэдэхгүй гэж хариулсан байдалтай харьцуулан үзвэл иргэн-цэргийн харилцааны гол асуудлуудын нэг болох Зэвсэгт хүчинд хэрэгжүүлэх иргэний хяналтыг цэргийн байгууллагыг байнга хардах, хянах гэсэн утгаар бус харин цэргийн болон иргэний удирдлага харилцан бие биенээ нөхсөн хамтын ажиллагаагаар үйл ажиллагаагаа явуулж, улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт түрэмгийллээс хамгаалах, байгалийн гамшиг, дотоодын дэг журам алдагдсан үед иргэний удирдлагад захирагдан орон нутгийн удирдлага, иргэний цагдаа, тагнуулын байгууллагыг дэмжин ажиллах, олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд хувь нэмрээ оруулах, энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох, байлдааны хүчин чадавхиа байнга нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд үндсэн зорилго, зорилтоо чиглүүлэх учиртай болж байна.

МУ-ын ЗХ-ний нэр хүнд олон нийтийн дунд ямар түвшинд байгаа талаар судалгаа явуулахад судалгаанд оролцогчдын 45% сайн, 40% дунд, 8% мэдэхгүй, 7% муу гэсэн үнэлгээний хувьтай байгаа нь өндөр түвшинд хүрээгүй байна.

Монгол Улсын Энхийг сахиулах үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээ хамгийн өндөр буюу “Маш сайн”-31%-тай байгаа бол Оюутан цэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг “Сайн”-35%, Цэрэг татлагын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг “Сайн”-32%-тай үнэлсэн байгаа нь Зэвсэгт хүчний мэргэжлийн ур чадвар дээшилж, үүрэг гүйцэтгэх бэлэн байдал сайжирч, Энхийг сахиулах ажиллагаануудад амжилттай сайн оролцон, олон улсад нэр хүнд нь өсөхийн зэрэгцээ нэг хүнд ногдох энхийг сахиулагчдын тоогоороо манай улс Ази тивдээ тэргүүлж байгаа үр дүнтэй холбон тайлбарлаж болно.

Монгол Улсын аюулгүй байдлын талаарх таны ойлголт ямар түвшинд байдаг вэ? гэсэн асуултад 16% нь сайн, 56% нь дунд, 23% нь муу, 6% нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд харин Таны бодлоор манай улсад доорх аюулгүй байдлын орчин хэрхэн хангагдсан гэж үзэж байна вэ? гэсэн асуултад хариулсан байдлаас үзэхэд, хүнсний аюулгүй байдал муу-47%, Эдийн засгийн аюулгүй байдал муу-46%, Мэдээллийн аюулгүй байдал муу-46%-тай байгаа нь анхаарал татаж байна.

Ардчилсан нийгэмд Зэвсэгт хүчний гол үүрэг нь гадны цэргийн аюул заналаас улс орноо батлан хамгаалахад чиглэгдэнэ. Мөн улс орны батлан хамгаалах бодлогыг боловсруулах үйл явцад бүс нутгийн стратегийн нөхцөл байдлыг урьдчилан таамаглах шаардлагатай нь ач холбогдолтой болно.

Улс орны цэргийн байгууллагын босоо удирдлага, аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар шийдвэр гаргах үйл явц, батлан хамгаалах нөөцийн хангалт болон зардлын хэмжээ, Зэвсэгт хүчний зохион байгуулалтын бүтэц, байрлал зэрэг нь цэргийн аюулд хандах үндэсний хандлагаас үлэмж хэмжээгээр хамаарч байна.

Батлан хамгаалах стратеги нь аюулыг ухамсарлан ойлгож хүлээн авах нийгмийн сэтгэл зүйн түвшингээс хамаарна. Хэрэв аюул занал хангалттай өндөр байгаа бол батлан хамгаалах шийдвэрийг хүлээн авах үйл явц хурдан байх төдийгүй Үндэсний Аюулгүй байдлыг хангах тогтолцоо илүү “цэрэгжсэн” загвартай болно. Иргэний байгууллагууд ч үүнд хүлээцтэй ханддаг байна. Харин улс орон стратегийн таатай тогтвортой нөхцөл байдалд байгаа эсвэл томоохон, найдвартай эвсэл холбооны бүрэлдэхүүнд орж байгаа бол түүний Үндэсний Аюулгүй байдлыг хангах тогтолцоо илүү тунгалаг байж, төрийн бусад бүтцүүдээс төдийлөн ялгардаггүй байна. Гэхдээ улс орны аюулгүй байдлын хүрээнээс ангид ямар ч цэргийн, цэрэгжсэн, цагдаагийн болон тагнуулын байгууллага оршин тогтнож, үйл

ажиллагаа явуулах ёсгүй бөгөөд эдгээр бүтцүүд нь иргэний хяналтын тогтолцоонд суурилсан улстөрийн нийтлэг үйл явцад оролцон ардчилсан засаглалд захирагдан нийгэмд үр ашигтай үйлчлэх ёстой гэж үзэх хандлага нийтлэг байна.

Төсвийг боловсруулахтай холбоотой Батлан хамгаалах яамны үндсэн үүрэг нь бодлого, үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, зорилго, зорилтыг биелүүлэх арга зам, биелэлтийг хянах шалгуур үзүүлэлтийг боловсруулан гаргах шаардлагатай юм.

Ардчилсан улсуудын хувьд Батлан хамгаалахын сайдын бодлого, үйл ажиллагааг тайлбарласан “Цагаан ном”-ыг Зэвсэгт хүчний хэмжээнд тарааж, улмаар Засгийн газрын бодлоготой нийцүүлэн Зэвсэгт хүчний төсвийн төслийг боловсруулан гаргадаг туршлага байна. Батлан хамгаалах яаманд ажиллаж буй энгийн албан хаагчид нь стратегийн үнэлгээ, шинжилгээ хийж, харин цэргийн албан хаагчид оперативын шаардлагатай мэдээллийг боловсруулж, “цагаан ном”-д оруулдаг байна.

Олон нийтийн санаа бодлын судалгаагаар Зэвсэгт хүчин нь иргэдийн итгэх итгэлийн түвшинд дунд болон дундаас дээш түвшинд хүрсэн байна.

Зэвсэгт хүчинд үндэсний институц гэж итгэх нь маш чухал ач холбогдолтой бөгөөд үйл ажиллагааны нөхцөлтэй шууд холбоотой болно.

Олон нийт, олон нийтийн бодлого боловсруулагчид нь тодорхой нөлөө үзүүлэх боломжтой зорилтот олон түмэн боловч тэд мөн Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, санхүүжилт, ирээдүйн талаар шийдвэр гаргагчид юм. Энэ бүхэн нь гүйцэтгэлийн чанарт нөлөөлдөг боловч гадаад олон нийттэй харьцуулахад энэ нь Зэвсэгт хүчний дотоод олон нийт буюу бие бүрэлдэхүүний хамтын ажиллагаа, зөв төлөвлөлтөөс хамаардаг талаар гадаад улс орнуудын судалгаанд дүгнэсэн байна. Үүнтэй холбогдуулан Зэвсэгт хүчин эрхэм зорилгоо хэрэгжүүлэхдээ хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд нээлттэй, ил тод, иргэний нийгэмтэй хамтран ажиллах, олон нийтэд чиглэсэн төрөл бүрийн төсөл хэрэгжүүлэх, алба хаагчдын нийгмийн асуудалд анхаарах шаардлагатай байна.

Мөн гадаадын зарим орны туршлагаар иргэн-цэргийн харилцааны хэлтэс нь батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа бүх ажилтнуудад болон олон нийтэд зориулсан веб порталыг ажиллуулж, өдөр бүр өргөн хүрээтэй тулгамдсан асуудал, арга хэмжээний талаар ажилтнууддаа мэдээлэх ба энэ нь төрөл бүрийн хууль эрх зүйн актууд, спорт, боловсрол, сургалт, бусад чиглэлээр тогтмол хэсгүүдийг багтаасан байвал зохино гэж үзлээ.

Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах стратеги, төлөвлөлтийг ихэнх тохиолдолд улстөрийн түвшинд шийдвэр гарган хэрэгжүүлдэг нь Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогод ардчилсан хяналт тавих, үйл ажиллагааг нь бодлогын хувьд ард түмний эрх ашигт нийцүүлэх үндсэн зорилготой юм. Хэдийгээр батлан хамгаалах салбарт хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг бодит хэмжүүрээр үнэлэх боломжгүй боловч улстөрийн болон цэргийн удирдлага батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны зорилгыг тодорхойлж, энэхүү бодлого, үйл ажиллагааг хэмжих хэмжүүр, шалгуур үзүүлэлтийг хамтран тодорхойлох шаардлагатай байна.

БХЯ нь Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэхдээ захиргааны удирдлагаар хангах, цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, цэргийн алба хаагчдын эрх ашиг сонирхлыг хамгаалах, батлан хамгаалах, цэргийн бодлогыг ард иргэдийн дотор сурталчилж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, “Батлан хамгаалахын Цагаан ном”-ыг эрхлэн гаргах, Зэвсэгт хүчний байлдааны болон дайчилгааны бэлэн байдал, сургалт бэлтгэл, зэвсэглэл-техник, материал хэрэгслийн хангалтын байдалд хяналт тавих, цэргийн үйл ажиллагааны бодит үр дүнд дүгнэлт хийх байдлаар ажиллаж байна.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлага дор үйл ажиллагаагаа явуулах Батлан хамгаалах яам нь улсын хэмжээнд төрийн батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг удирдан зохицуулах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд иргэний хяналтыг хэрэгжүүлэгч үндсэн субъект болж байна.

Батлан хамгаалахын төлөвлөлт хийхдээ бодлогын шинжилгээний тинк танк загвар бүхий байгууллагууд, мэргэжлийн шинжээчдийн бүлэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, БХЯ-ны харилцан ойлголцол бүхий хамтын ажиллагааны тогтсон бүтэц механизмыг бий болгох шаардлагатай байна. Ингэснээр харилцан уялдаатай, бодит байдалд үндэслэгдсэн, хэрэгжихүйц төлөвлөлт боловсруулагдах арга зүйн боломж бүрдэнэ гэж үзлээ.

Батлан хамгаалах салбарын хөгжлийн хөтөлбөр, төслийг батлуулахдаа шаардагдах нөөцийг нягт нямбай тооцож батлуулах шаардлагатай бөгөөд үнийн өсөлтөөс шалтгаалсан эрсдэлийг тооцох, хэрхэн шийдвэрлэхарга замыг /эрсдэлийн сан бүрдүүлэх/ хамтад нь шийдсэнээр батлан хамгаалахын төлөвлөлт хэрэгжих бодит боломж бүрдэх боломжтой болох юм.

Мэдээллийн хэрэгсэл, албан болон албан бус уулзалт, судалгаа шинжилгээний үр дүнг ашиглах замаар аюулгүй байдлын гол асуудлаар олон

нийтийн дунд мэтгэлцээн, хэлэлцүүлэг зохион байгуулах, аюулгүй байдал болон батлан хамгаалах үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлэх, Аюулгүй байдал болон батлан хамгаалах асуудлаар шийдвэр гаргахдаа олон нийтийн санал бодлыг тусгах, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, сургалт судалгааны ажлын өнөөгийн түвшинг сайжруулж, төр, засгийн болон иргэний нийгмийн зүгээс санхүү хөрөнгийн төдийгүй эрх зүй, удирдлага зохион байгуулалтын өргөн дэмжлэгийг бий болгох шаардлагатай байна.

Батлан хамгаалах үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн санаа бодлын судалгааны асуултын хариултын тухай бүрт нь дүгнэлт гарсан тул давхардуулан ерөнхий дүгнэлтэд оруусангүй.

“Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээ. Шифр: “Рейтинг” сэдэвт судалгааны ажлаараа Монгол Улсын Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон нийтийн санал санаа бодолд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлон цаашдын бодлого үйл ажиллагааны санал боловсруулах зорилго ханган биелүүлсэн болно.

Санал:

Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээнээс үзэхэд дараах саналыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

1. Монгол Цэргийн өдрийг тохиолдуулсан Батлан хамгаалах багц хуулийн сурталчилгааг хийх, арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр аймаг, нийслэл, сум дүүргийн хэмжээнд зохион байгуулан явуулж байх;
2. Орчин үеийн цэргийн зэвсэглэл, техникийн хангалтыг хийх үүний тулд Батлан хамгаалах төсвийг нэмэгдүүлэх;
3. Анги салбарын цэргийн сургалтыг сайн зохион байгуулж явуулж, энхийг сахиулах ажиллагаанд тогтмол оролцуулж байх.
4. Оюутан цэргийн сургалтыг төв орон нутаг жил бүр чанартай зохион байгуулж явуулах;
5. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг аймаг, сумад хэрэгжүүлэх ажлыг жил бүр явуулж байх.

ЭШЛЭЛ АВСАН, АШИГЛАСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. БХС-ын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/313 дугаар тушаал, “Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын хөтөлбөр”.

2. БХС-ын 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/267 дугаар тушаал, “Цэргийн бэлтгэл албаны сургалтын журам”.
3. БХЭШХ, “Зэвсэгт хүчин ба олон нийтийн үнэлэмж” шифр: “Үнэлэмж” сэдэвт судалгааны ажлын тайлан, УБ., 2011.
4. БХЭШХ, Цэргийн нэр томъёоны тайлбар толь, УБ., 2014.
5. Дашзэвэг.Ц, Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл, УБ., 2018.
6. Моломжамц.Л, “Байлдааны бэлтгэл сургалтын удирдлагын зарим асуудал” УБ., 1980.
7. Монгол Улсын “Гамшгаас хамгаалах тухай” УБ.,2018.
8. Монгол Улсын“Орон нутгийн хамгаалалтын тухай” хууль, УБ., 2016.
9. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль (Шинэчилсэн найруулга) УБ.,2016.
- 10.Монгол Улсын Дайны байдлын тухай" хууль,УБ.,2016.
- 11.Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль (шинэчилсэн найруулга)УБ.,2016.
- 12.Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг.
- 13.Монгол Улсын хууль“Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2018.
- 14.Монгол Улсын Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль.
- 15.Монгол Улсын Цэргийн албанытухай хууль, УБ., 2016.
- 16.Паламдорж.Ш нар “Зэвсэгт хүчний стратеги”, УБ., 2017.
- 17.Паламдорж.Ш нар “Батлан хамгаалах стратеги” УБ., 2016.
18. БХЯ, Батлан хамгаалах яамнаас 2016-2020 онд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, УБ., 2020.6 сар
- 19.Паламдорж.Ш нар “Монгол Улсын төр цэргийн зүтгэлтэн дэслэгч генерал Ш.Жадамбаа-1, УБ., 2009.
- 20.Паламдорж.Ш нар “Мэргэжлийн Зэвсэгт хүчин, түүний чиг хандлага, УБ., 2010.
- 21.Содбилэг.Б, “Үндэсний аюулгүй байдлыг хангах субъект-Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг боловсронгуй болгох нь” докторын дисс, УБ., 2017.

“БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ. ШИФР: “РЕЙТИНГ” СЭДЭВТ ТӨСЛИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ЭКСПЕРТИЗИЙН КОМИССЫН ДҮГНЭЛТ

2020.11.05.

БХЭШХ-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр томилогдсон комиссын гишүүд бид БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн захиалгаар БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвд гүйцэтгэсэн “Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээ” сэдэвт судалгааны ажлын тайлантай танилцан 2020.06.08-ны өдөр дүгнэлт гаргасан. Гаргасан дүгнэлтийн дагуу дахин боловсруулалт хийж, сайжруулсан судалгааны ажлын тайлантай танилцан дараах дүгнэлтийг гаргалаа.

“Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үнэлгээ, дүн шинжилгээ” сэдэвт судалгааны ажлын тайланг Удиртгал, 2 бүлэг, 4 дэд бүлэг, дүгнэлт, санал, төгсгөл, эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт гэсэн бүтэцтэйгээр нийт 52 хуудастайгаар боловсруулсан нь агуулга, багтаамжийн хувьд бүтцийн төлөвлөгөө, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан гэж үзэх үндэстэй байна. Мөн 1.2 дугаар бүлгийн “БХЯ-ны бодлого, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээ” нэртэй дэд бүлэгт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан үнэлгээний аргачлал гарган БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг үнэлсэн байдал нь оновчтой шийдэл болсон байна. Харин бүтцийн төлөвлөгөө нь судалгааны ажлын даалгавраас бага зэрэг зөрүүтэй байгаа нь онолын түвшинг тодорхойлон гаргаж ирэхэд бий болсон асуудал гэх үндэстэй байгаа тул судалгааны ажлын чанарыг алдагдуулахгүй байна гэж дүгнэлээ.

Тус судалгааны ажлыг нэгдүгээр бүлэг “Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаарх иргэдийн оролцооны агуулга, түүний хэлбэрийг хангах үндэслэл”-ийг Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хэлбэр, Батлан хамгаалах эрхзүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодлын шинжилгээ гэсэн хоёр дэд бүлэгтэй, Хоёрдугаар бүлэг “Монгол Улсын Зэвсэгт хүчний талаар олон нийтийн үнэлгээний судалгаа”-г Зэвсэгт хүчний удирдах байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, цэргийн алба хаагчдын өгсөн үнэлгээ, Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг

хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог хангах боломж гэсэн хоёр дэд бүлэгтэйгээр тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон нийтийн санал санаа бодолд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлон цаашдын бодлого үйл ажиллагааны санал боловсруулах зорилго тавин ажиллажээ. Судалгааг хийхдээ зорилтот бүлгээс мэдээлэл авах, чанарын болон тоон шинжилгээний аргыг хэрэглэж, судалгааны ажлын түүврийн зохистой хэмжээг хангах үүднээс хүн амын төвлөрөл бүхий газруудыг сонгон, нийслэлийн 6 дүүрэг, цэргийн томоохон анги нэгтгэл байрлаж буй 6 аймгийн нийт 3000 гаруй иргэдээс санамсаргүй түүврийн аргаар асуулгын судалгаа авахын зэрэгцээ судалгааны мэдээллийг нэгтгэн, зарим асуудлууд дээр экспертүүдтэй ярилцлага хийж, чанарын болон тоон шинжилгээний аргачлалуудыг ашиглан хамаарлын шинжилгээ хийж дүгнэлт гаргасан, урьд онуудын судалгааны үр дүнтэй харьцуулалт хийж, үр дүнгийн өсөлт бууралтын шалтгааныг тодорхойлох оролдлого хийсэн нь шинэлэг бөгөөд үр дүнтэй судалгаа болсныг харуулж байна. Энэхүү судалгаагаар батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаарх иргэдийн оролцооны агуулгыг тодорхойлж, батлан хамгаалах эрх зүйн хэрэгжилт, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодолд шинжилгээ хийсэн нь салбарын цаашдын бодлого, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх, мөн тодорхой аргачлалаар БХЯ-ны бодлого, үйл ажиллагааг үнэлж, дүгнэсэн байдал нь гол ач холбогдолтой байна гэж үзлээ.

Судалгааны үр дүнг захиалагчид хүлээлгэн өгч судалгааны эргэлтэд оруулахын тулд тайланд байгаа зарим нэг алдаа дутагдлыг засаж, залруулах нь зүйтэй гэж шинжээчдийн комиссын гишүүд бид үзэж байна. Тухайлбал:

1. Судалгааны ажлын зураг, хүснэгтүүд дэх гарчгийг тэр чигээр нь асуултаар нь бичсэн байгааг анхаарч, засах. Тухайлбал, хуудас 12-ын 3 дугаар зураг, хуудас 13-ын 4 дүгээр зураг, хуудас 16-ын 5 дугаар зураг, хуудас 24-ийн 5 дугаар хүснэгт.
2. Хуудас 34-ийн 4 дүгээр хүснэгтийг 5, 5 дугаар хүснэгтийг 6 болгох.
3. Дэвшүүлж буй саналын хэсгийг дахин нягталж, Зэвсэгт хүчинд үр дүнтэй хэрэгжиж байгаа зарим саналуудыг хасах.

Эдгээр заасан дутагдлуудыг засаж залруулах боломжтой тул судалгааны ажлын үр дүн, шинжлэх ухааны ач холбогдолд нөлөө үзүүлэхгүй тул дурдсан алдаануудыг зассаны үндсэн дээр захиалагчид хүлээлгэн өгч тайланг судалгааны эргэлтэд оруулах боломжтой гэж үзлээ.

Иймд экспертизийн комиссын гишүүд бид цэргийн шинжлэх ухаан технологийн экспертизийн зааврыг үндэслэн энэхүү судалгааны тайланд дараах үнэлэлтийг өгч байна. Үүнд,

а. Судалгааны хэрэгцээ шаардлага нь БХЯ-ны ШУТЗ-ийн захиалгат судалгааны ажил - 10 оноо;

б. Судалгааны хүрээ нь тодорхой нэг төрлийн үйл явцад хамаарах - 8 оноо;

в. Сурвалж эх материалыг хэвлэл, ном зохиолоос дам ашигласан - 5 оноо;

г. Судалгааны уламжлалт аргыг хэрэглэсэн -3 оноо;

д. Онолын түвшин нь Д-3 “20” буюу “дунд” оноо;

е. “Цэргийн хэрэг, үйлдвэрлэлийн ач холбогдол” нь “20” буюу “Сайн” оноо;

ж. “Хэл найруулгын түвшин” нь - 10

Дүгнэлт: Төслийн тайланд өгсөн нийт оноо 76, “Д” ба “Е”-ийн үзүүлэлт “Сайн” байгаа тул уг төслийн тайланд “Хангалттай” гэсэн үнэлэлт өгч байна.

ЭКСПЕРТИЗИЙН КОМИССЫН ДАРГА:

ДОКТОР (Sc.D),
ПРОФЕССОР

Б.ӨЛЗИЙХУЯГ

ГИШҮҮД:

ДОКТОР (Ph.D),
ХУРАНДАА

Ц.ГАНДОРЖ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР,
ДЭД ХУРАНДАА

Б.ЭРДЭНЭЧИМЭГ